



## **НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2018, 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

*(Канад доллараар)*

*Орчуулга:*

*Энэхүү санхүүгийн тайлан нь Англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.*

Аудитын Англи хэл дээрх тайлантай дараах SEDAR [www.sedar.com](http://www.sedar.com) дахь компанийн хуудаснаас танилцана уу.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан  
(Канад доллараар)

	Тодруулга	2019.12.31	2018.12.31
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 5,106,863	\$ 1,748,249
Дансны авлага		70,361	113,412
Урдчилж төлсөн зардал		69,029	34,633
Эргэлтийн хөрөнгийн дүн		5,246,253	1,896,294
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	6	21,483,517	15,687,348
Хөрөнгө ашиглах эрх	7	137,064	-
Үндсэн хөрөнгө	8	105,998	125,277
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		21,726,579	15,812,625
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		<b>\$ 26,972,832</b>	<b>\$ 17,708,919</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
Арилжаа болон бусад өглөг		\$ 591,999	\$ 224,387
Түрээсийн өглөг	7	139,250	-
Хөрвөх боломжтой өр төлбөр	10	6,260,521	-
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>\$ 6,991,770</b>	<b>\$ 224,387</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	12	\$ 109,466,565	\$ 104,003,644
Нэмж төлөгдсөн капитал		16,829,920	16,110,116
Бусад хуримтлагдсан алдагдал		(1,958,616)	(955,713)
Нийт хуримтлагдсан алдагдал		(104,356,807)	(101,673,515)
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>19,981,062</b>	<b>17,484,532</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>		<b>\$ 26,972,832</b>	<b>\$ 17,708,919</b>

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 9)

Дагалдах тодруулгууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан “Петер К.Акерли”

ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан “Жон П.Бюрн”

ТУЗ-ийн гишүүн

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн алдагдлын дэлгэрэнгүй тайлан  
(Канад доллараар)

	Тодруулга	Дуусгавар болсон 12 сарын 31,	
		2019	2018
<b>Үйл ажиллагааны зардал</b>			
Хайгуул, үнэлгээний зардал	13	\$ 1,090,786	\$ 1,595,675
Ерөнхий ба удирдлагын зардал	14	1,615,724	2,120,390
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал		2,706,510	3,716,065
Санхүүгийн орлого		(36,512)	(50,816)
Хүүгийн зардал		165,934	-
Санхүүгийн хэрэгслээс үүдсэн үнэ цэнийн зөрүү		(143,124)	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз (олз)		(9,516)	(8,259)
<b>Цэвэр алдагдал</b>		<b>\$ 2,683,292</b>	<b>\$ 3,656,990</b>
Бусад дэлгэрэнгүй алдагдал:			
Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү		1,002,903	60,858
<b>Бусад дэлгэрэнгүй алдагдал</b>		<b>1,002,903</b>	<b>60,858</b>
<b>Нийт дэлгэрэнгүй алдагдал</b>		<b>\$ 3,686,195</b>	<b>\$ 3,717,848</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал		\$ 0.02	\$ 0.02
Нийт хувьцааны жигнэсэн дундаж тоо		178,522,823	155,104,960

Дагалдах тодруулгууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Өмчийн өөрчлөлтийн тайлан  
(Канад доллараар)

	Тодруулга	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
<b>2018.01.01-ний үлдэгдэл</b>		145,963,086	\$ 99,890,270	\$ 13,775,386	\$ (894,855)	\$ (98,016,525)	\$ 14,754,276
<b>Тайлант хугацааны нийт алдагдал</b>							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(3,656,990)	(3,656,990)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(60,858)	-	(60,858)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал	12	14,834,580	3,706,199	1,301,176	-	-	5,007,375
Хэрэгжүүлсэн опцион	12	1,628,750	407,175	(152,450)	-	-	254,725
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	1,186,004	-	-	1,186,004
<b>Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ</b>		16,463,330	4,113,374	2,334,730	-	-	6,448,104
<b>2018.12.31-ний үлдэгдэл</b>		162,426,416	\$ 104,003,644	\$ 16,110,116	\$ (955,713)	\$ (101,673,515)	\$ 17,484,532
<b>2019.01.01-ний үлдэгдэл</b>		162,426,416	\$ 104,003,644	\$ 16,110,116	\$ (955,713)	\$ (101,673,515)	\$ 17,484,532
<b>Тайлант хугацааны нийт алдагдал</b>							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(2,683,292)	(2,683,292)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(1,002,903)	-	(1,002,903)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал	12	25,922,044	4,895,464	414,401	-	-	5,309,865
Хэрэгжүүлсэн опцион	12	1,105,000	276,900	(107,100)	-	-	169,800
Олгосон ирээдүйд олгогдох хувьцааны эрх	12	1,615,030	290,557	(290,557)	-	-	-
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	703,060	-	-	703,060
<b>Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ</b>		28,642,074	5,462,921	719,804	-	-	6,182,725
<b>2019.12.31-ний үлдэгдэл</b>		191,068,490	\$ 109,466,565	\$ 16,829,920	\$ (1,958,616)	\$ (104,356,807)	\$ 19,981,062

Дагалдах тодруулгууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Мөнгөн гүйлгээний тайлан  
(Канад доллараар)

Тодруулга	Тайлант хугацаа 12 сарын 31	
	2019	2018
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Цэвэр алдагдал	\$ (2,683,292)	\$ (3,656,990)
Мөнгөн бус гүйлгээнүүд:		
Элэгдэл, хорогдол	32,248	20,904
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	703,061	1,186,004
Санхүүгийн орлого	(36,512)	(50,816)
Капиталжуулсан хүүгийн зардал	10 162,051	-
Мөнгөн бус гадаад валют	26,332	(8,259)
Хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийн үнэ цэнийн өөрчлөлт	(178,972)	-
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	392,315	74,124
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,582,769)</b>	<b>(2,435,033)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Энгийн хувьцаагаар татан төвлөрүүлсэн цэвэр дүн	12 5,309,865	5,007,375
Хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээгээр татан төвлөрүүлсэн цэвэр дүн	10 6,357,763	-
Опцион хэрэгжүүлсний төлбөр	12 169,800	254,725
Түрээсийн төлбөрийн эргэн төлөлт	(7,604)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>11,829,824</b>	<b>5,262,100</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал	(6,804,128)	(4,363,017)
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн зардал	(10,653)	(16,077)
Хүүгийн орлого	36,512	50,816
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(6,778,269)</b>	<b>(4,328,278)</b>
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(110,172)	24,258
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)	3,358,614	(1,476,953)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд	1,748,249	3,225,202
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст	\$ 5,106,863	\$ 1,748,249

Дагалдах тодруулгууд нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг Монгол улсад эрхэлдэг компани юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Биржид “ERD”, Монголын Хөрөнгийн Биржид “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

Эрдэнэ Ресурс нь үнэт болон суурь металлын хайгуул, хөрөнгө оруулалт болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг Монгол улсын баруун өмнөд бүсэд эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт орших Хөндий Алтны Төсөл юм.

2019 оны 10-р сард Компани нь Хөндий Алтны Төслийн хараат бус Техникийн тайланг танилцуулсан бөгөөд энэхүү тайланд Баян Хөндий алтны ордын урьдчилсан ТЭЗҮ, Баян Хөндий алтны ордоос хойш 16 км-т орших Алтан Нар ордын шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) багтсан. Компанийн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх, одоогийн эрдсийн нөөцийг эдийн засгийн хувьд үр ашигтайгаар ашиглах нь Компанийн санхүүжилт амжилттай татан төвлөрүүлэх, төслүүдийг үргэлжлүүлэн хөгжүүлэх үйл ажиллагаанаас хамаарна.

## 2. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчим:

Энэхүү санхүүгийн нэгтгэсэн тайланг ирээдүйд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, бизнесийн хэвийн үйл ажиллагааны туршид хөрөнгийн өгөөжийг хүртэх, өр төлбөр, төлбөрийн үүргээ үйл ажиллагааны хүрээнд биелүүлэх боломжтой гэх тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчимд тулгуурлан боловсруулав. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчим хэр зохистойг үнэлэхийн тулд гүйцэтгэх удирдлагын зүгээс тайлант хугацааны төгсгөлөөс хойш ирээдүйн 12 сарын хугацаанд үүсч болох боломжит мэдээллийг харгалзан үзсэн. Гүйцэтгэх удирдлага нь дүгнэлт гаргахдаа үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд Компанийн чадварт эргэлзээ төрүүлж болзошгүй үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдлуудыг тооцоолсон болно. Эдгээрийг доор тайлбарлав.

Компани нь 2018, 2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон тайлант жилд алдагдал хүлээж, мөнгөн гүйлгээ хасах утгатай гарсан бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт хуримтлагдсан алдагдал \$104,356,807 байна. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар \$1,671,907 байсан эргэлтийн хөрөнгө 2019 оны 12 сарын 31-нд \$4,628,557 болж, \$2,956,650-аар өссөн. Энэхүү эргэлтийн хөрөнгө нь 2020 оны 3-р улирал хүртэл төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд хангалттай гэж үзэж байна. Компанийн хөрөнгөө борлуулах, өр төлбөрөө барагдуулах буюу хайгуулын хөтөлбөрүүдээ өргөжүүлэх чадвар нь хөрөнгийн санхүүжилтээ баталгаажуулах, хамтын хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулах буюу хөрөнгөө бэлэн мөнгөнд хөрвүүлэх зэрэг нь тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмыг хангаж, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд нөлөөтэй гэж гүйцэтгэх удирдлага тооцоолсон болно. Нэмэлт санхүүжилт шаардлагатай эсэх, хугацаа төлөвлөлт зэрэг нь Компанийн хайгуулын тасралтгүй үргэлжлэх хөтөлбөрүүдийн үр дүн болон зах зээлийн нөхцөл байдлаар тодорхойлогдоно. Компани нь ирээдүйд шаардлагатай болж болзошгүй хөрөнгийг босгох чадвартай эсэхийг тооцоолох боломжгүй.

Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмын төсөөлөл бодитой бус байсан бол нэгтгэсэн санхүүгийн тайланд шаардлагатай тохируулалтыг тусгахгүй. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмын суурь нь бодитой бус байх тохиолдолд хөрөнгийн дансны үнэ, тайлагнасан орлого, зардал, санхүүгийн байдлын тайлангийн ангилалд тохируулалт хийх шаардлагатай болно.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 3. Тайлангийн үндэслэл

### а) Нийцлийн тайлан

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу боловсруулсан. Тодруулга 4-д тусгасан нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг (Тодруулга – 5-аас бусад) бүх хугацааны санхүүгийн мэдээллийг боловсруулахад ашигласан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг тайлагнахыг 2020 оны 3 сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар зөвшөөрсөн болно.

### б) Хэмжилтийн үндэслэл

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ худалдах боломжтой санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн ашиг, алдагдлыг оролцуулахгүйгээр түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн. Мөнгөн гүйлгээнээс бусад мэдээлэл нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт бүртгэлээр боловсруулагдсан.

### с) Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Санхүүгийн тайланг бэлтгэх явцад Компанийн удирдлага нь тайлан болон холбогдох тодруулгуудтай холбоотойгоор материаллаг өөрчлөлт, нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалууд дэвшүүлэхийг шаарддаг. Тооцоолол, таамаглалууд нь олон хүчин зүйлд үндэслэх бөгөөд түүхэн туршлага, одоогийн болон хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт мэдээллүүдийг ашигласан. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрөх магадлалтай. Удирдлагын тооцоолол болон таамаглал, үндэслэл, төсөөлөл болон эдгээр нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, тодруулгуудад хэрхэн нөлөөлөх талаар доор танилцуулав.

#### *Тооцоолол, дүгнэлтүүд*

Компанийн нягтлан бодох бүртгэлийн журмыг хэрэгжүүлэн, тайланг боловсруулах үйл явцад Компанийн удирдлагууд доор дурдсан дүгнэлтүүдийг гаргасан. Эдгээр дүгнэлтүүд нь нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөөлөх голлох хүчин зүйлсийг агуулна.

- i) *Төлбөрийн хэрэгсэл, валют:* Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан Компани болон охин компани тус бүр нь үйл ажиллагаа явуулахад анхдагч зах зээлийн валютыг ашигладаг. Толгой компани Канад доллар, Монгол дахь охин компаниуд Монгол төгрөгөөр үйл ажиллагаа эрхэлдэг.
- ii) *Хөрөнгийн дансны үнэ болон үнэ цэн бууралтын тооцоолол:* Эргэлтийн бус хөрөнгүүдийг тайлант хугацаа бүрт үнэ цэнээ алдсан эсэхийг шалгадаг. Магадлалтай үзүүлэлтийн хувьд хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг тодорхойлон, дансны дүн нь нөхөгдөх дүнгээс давуу байхаар үнэ цэнийн бууралтын гарзыг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх дүнг ашиглалтын үнэлгээ, эсхүл борлуулсан орлогоос борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль илүүгээр тооцоолно.

Ашиглалтын үнэлгээ нь хөрөнгийн үргэлжилсэн хэрэглээ, түүний эцсийн хэрэглээнээс өсөхөөр хүлээгдэж буй ирээдүйн бэлэн мөнгөний урсгалын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгддэг. Өнөөгийн үнэ цэнийг хөрөнгийн эрсдэлд тохируулсан татварын өмнөх хорогдуулалтын хүүгийн түвшинд тохируулан тодорхойлдог. Ирээдүйн мөнгөн урсгал нь хүлээгдэж буй олборлолт, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ (өнөөгийн болон түүхэн үнэ, үнийн чиг хандлага болон холбогдох хүчин зүйлсийг авч үздэг) ба нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээлтийн зардал, татвар роялти болон ирээдүйн хөрөнгийн зардлуудаас хамааралтай.



# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 3. Тайлангийн үндэслэл (үргэлжлэл)

- iii) *Хайгуул, үнэлгээний хөрөнгө ба зардлууд*: Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хайгуул, үнэлгээний хөрөнгө ба зардлуудыг тооцоолохдоо нөөцийн тооцоолол нь ирээдүйд эдийн засгийн үр ашиг (олборлолт, борлуулалтаас) өгөх боломжтой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай. Компани нь эдгээр хүдрийн биетийг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах боломжтой эсэхийг нотлох шаардлагатай. Мөн Компани нь эдгээр хүдрийн биетийг олборлоход шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлж чадна гэсэн баталгаа байхгүй.

### *Тооцооллууд болон төсөөллүүд*

Ирэх санхүүгийн жилд хөрөнгө болон өрийн дүнд материаллаг өөрчлөлт оруулах, эрсдэл болохуйц хүчин зүйлсийг доор дурдав. Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан гарах үед боломжтой байсан шалгуур, параметерт тулгуурлан тооцоолол, төсөөллийг боловсруулсан. Одоогийн тооцоолол, төсөөлөл нь ирээдүйд Компанийн урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх боломжтой.

- i) *Хайгуул болон үнэлгээний хөрөнгө ба зардлууд*: Хайгуул, үнэлгээний хөрөнгө ба зардлуудыг тооцоолохдоо нөөцийн тооцоолол нь ирээдүйд эдийн засгийн үр ашиг (олборлолт, борлуулалтаас) өгөх боломжтой эсэх талаар төсөөлөл, тооцооллуудыг хийх шаардлагатай. National Instrument 43-101 ("NI 43-101") буюу нөөц тайлагнах тайлагналын стандарт нь нөөцийг хэрхэн ангилан (баттай, бодит болон боломжит г.м) тооцоолол хийдэг. Энэхүү тооцооллууд нь Компани хайгуул болон үнэлгээний зардлыг хойшлуулах эсэхээс шууд хамаардаг. Мөн шинэ мэдээ мэдээлэл гарснаас шалтгаалан эдгээр тооцоолол, төсөөллүүд нь өөрчлөгдөх магадлалтай. Худалдан авалтын зардал нөхөн төлөгдөх боломжгүй талаар мэдээлэл гарсан тохиолдолд орлогын тайланд капиталжуулсан дүнг данснаас хасан тооцно. Компанийн удирдлагын гаргасан тооцоололд тулгуурлан үр дүн гарсан тохиолдолд Компани тохирох арга хэмжээг авч ажиллана.
- ii) *Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр*: Үнэт цаас, хувьцаанд суурилсан төлбөрийг олгож буй өдрийн бодит үнэ цэнээр хэмждэг. Бодит үнэ цэнийг Блэк-Шолсийн ("Black-Scholes pricing model") үнэлгээний загварыг ашиглаж тооцоолдог ба энэ нь хүлээгдэж буй хэлбэлзэл, бусад хувьсагчидтай холбоотой зах зээлд бэлэн буй мэдээлэлд үндэслэж шийдэл, дүгнэлт гаргахыг шаарддаг.
- iii) *Хөрвөх нөхцөлтэй өр төлбөр*: 2019 онд Эрдэнэ Ресурс нь хөрвүүлэлт хийх сонголттой дериватив опцион бүхий өрийн бичиг гаргасан ба эзэмшигч нь цаашид хэсэгчлэн ба бүхэлд нь компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой. Энэхүү хөрвөх боломжтой зээлийг удирдлага өр төлбөр хэмээн тодорхойлсон. Өр төлбөрийг бодит үнэ цэнд тулгуурлан бүртгэсэн бөгөөд тайлант хугацаануудад үнэлгээг дахин хийсэн. Бодит үнэ цэнийг бином опционы моделээр үнэлэн, бодит үнэ цэнийг үнэлэх хугацаанд боломжтой мэдээлэлд тулгуурлан өөрчлөлтийн магадлал, эрсдэлгүй хүүгийн түвшин болон зээлийн эрсдэл зэргийг харгалзан тооцоолсон.
- iv) *Нөхөн сэргээлтийн тухай*: Удирдлагын зүгээс жилийн хугацаанд бий болсон баримт, нөхцөлд үндэслэн талбайн нөхөн сэргээлтийн тухай шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт

Дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь хэрэв өөрөөр дурдаагүй бол эдгээр бодлогууд нь тайлагнасан бүх хугацаанд тууштай хэрэглэгдэнэ.

### а) Нэгтгэлийн үндэслэл

2018, 2019 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилийн хувьд санхүүгийн нэгдсэн тайланд Эрдэнэ Ресурс Девелопмент Компани болон түүний охин компаниуд багтсан. Үүнд: Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресурс ХХК (Монголын хайгуулын компаниуд) багтсан.

Охин компаниудыг толгой компани удирддаг бөгөөд удирдлагыг шилжүүлэх хүртэл санхүүгийн тайлагналд охин компаниудын санхүүгийн тайланг тусгана.

Компани дундын үлдэгдэл, гүйлгээнүүд болон хэрэгжээгүй орлого, зарлагыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй. Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд компани хоорондын үлдэгдэл гүйлгээг хасдаг. Үнэ цэнийн бууралтын нотолгоо байхгүй тохиолдолд бодит бус алдагдал нь бодит бус ашигтай адил аргаар хасагддаг.

### б) Гадаад валют

Компанийн үйл ажиллагааны бүртгэлийн валют нь Компани болон охин компани тус бүрийн үйл ажиллагаа явуулж буй улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг ашигладаг. Хуулийн этгээд тус бүрийн санхүүгийн тайланг бэлтгэж байхад хуулийн этгээдийн ашигладгаас өөр валютаар (гадаад валют ) хийсэн гүйлгээг тухайн өдрийн ханш давамгайлж буй валютаар тооцно. Тайлангийн төгсгөл бүрт гадны валютаар хийгдсэн бүртгэлүүд нь тухайн өдрийн валютын ханшаар дахин хөрвүүлэгдсэнээр нэгдсэн алдагдлын дэлгэрэнгүй тайланд валютын зөрүүний олз эсхүл гарз хэмээн бүртгэх үндэслэл болно.

Валютын ханшийн өндөр зөрүүтэйгээс бусад үед орлого зардлын зүйлсийг тухайн хугацааны дундаж валютын ханшаар тооцно. Валютын ханш өндөр зөрүүтэй үед гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар тооцно. Үнэт цаасны гүйлгээ хийх тохиолдолд гүйлгээ хийсэн тухайн өдрийн ханшаар тооцно. Гадаад валютаар тооцогдсон хөрөнгө, өр төлбөрийн хувьд валютын зөрүү гарсан тохиолдолд бусад хуримтлагдсан хөрвүүлгийн залруулгын орлого (алдагдал)-д тооцогдоно.

Гадны үйл ажиллагааны хяналтын алдагдлын хувьд бүх ханшийн зөрүүг Компанийн эзэмшигчидтэй холбоотой үйл ажиллагааны өмчөөр хуримтлуулсан ба орлогын тайланд борлуулалтын ашиг эсвэл алдагдал байдлаар бичсэн.

### с) Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хэрэглүүр нь СТОУС 7, Санхүүгийн хэрэглүүр: Тайлагнал, НББОУС 32, СТОУС 9, санхүүгийн хэрэглүүрийн тайлагналын дагуу боловсруулагдан, тайлагнагдсан. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээс бусдаар санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг нэмсэн бодит үнэ цэнээр тооцогдоно. Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдсон санхүүгийн хөрөнгө нь гүйлгээний зардал, анхны хүлээн зөвшөөрөлтийг зарлагадсан бодит үнэ цэнээр тооцогдоно.

Үнэ цэнийг ангилахдаа тухайн нийт үнэ цэнийг бүрдүүлж буй доод зардалд тулгуурладаг. Дараах мэдээлэлд Компанийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг ангилж, хэмжих нэгжээр илэрхийлэв.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

Төрөл	Ангилал	Хэмжих нэгж
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	Санхүүгийн хөрөнгө	Бодит үнэ цэн
Авлага	Санхүүгийн хөрөнгө	Элэгдэл тооцсон зардал
Худалдаа болон бусад өглөг	Санхүүгийн өр төлбөр	Элэгдэл тооцсон зардал
Хөрвөх нөхцөлтэй зээл	Санхүүгийн өр төлбөр	Элэгдэл тооцсон зардал
Хөрвөх нөхцөлтэй зээл – хөрвөх опцион	Санхүүгийн өр төлбөр	Бодит үнэ цэн

Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг доорх байдлаар ангилав:

- i) Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө, хадгаламж, төв банкны үнэт цаас болон 90 хоног доторх валютын зах зээлийн хөрөнгө оруулалтын хэрэгслийг багтаах бөгөөд бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.
- ii) Авлага нь элэгдэл тооцсон зардлаар ангилагдана.
- iii) Худалдаа болон бусад өглөг нь элэгдэл тооцсон зардлаар хэмжигддэг. Санхүүгийн өр төлбөрийг хүчингүй болох үед буюу гэрээнд заасан үүргийг цуцалсан, гүйцэтгэж дууссан эсвэл хугацаа нь дууссан үед данснаас хасдаг.
- iv) Хөрвөх боломжтой зээл нь элэгдэл тооцсон зардал болон холбогдох хөрвөх опцион, ашиг алдагдал нь бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

### d) Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Хайгуулын өмнөх зардлыг зардлаар хүлээн зөвшөөрдөг. Эрдсийн нөөц тогтоохтой холбоотой бүх шууд зардлыг хайгуулын төсөл тус бүрээр катипалжуулна. Хайгуулын төсөл эсвэл талбайн боломжийг тодорхойлж, ТУЗ-өөр батлагдаж хайгуул, үнэлгээний зардал капиталжих хүртэлх хугацаанд гарсан хайгуулын зардлыг үйл ажиллагааны зардлаар зарлагадна.

Хайгуул, үнэлгээний хөрөнгийг эхлээд зардал байдлаар хэмжин, биет хөрөнгөөр ангилдаг. Хайгуул, үнэлгээний хөрөнгөд: хайгуул, судалгаа хийх, хайгуулын өрөмдлөг, суваг малталт, дээж авах эрхийг олж авах болон төслийн хайгуул, үнэлгээтэй холбоотой бусад шууд зардлууд орно. Төсөл нь техник эдийн засгийн болон арилжааны үүднээс үр ашигтай эсэхийг тодорхойлон, тодорхой ашиг сонирхолтой холбоотой ажлыг гүйцэтгэх шийдвэр гарсан бол холбогдох хайгуул, үнэлгээний хөрөнгийг үнэ цэнийн бууралтаар нь туршиж, балансыг нөөцийн төсөл, үйлдвэр, тоног төхөөрөмжид дахин ангилна.

Хайгуул, үнэлгээний үнэ цэнийн бууралтыг нягтлахдаа хөрөнгийн дансны дүн нь нөхөн төлөгдөх дүнгээс давж байвал тус бүрээр нь эсвэл мөнгө бий болгох нэгжийн түвшинд дахин нягтална. Үүнийг бий болоход, тодорхойлсон санхүүгийн жилд дансны дүнгийн эсрэг бүрэн барина.

Хайгуул, үнэлгээний хөрөнгийг тогтмол дахин үнэлдэг ба эдгээр зардлыг хамгийн багадаа дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан үед шилжүүлнэ:

- i) Эдгээр зардлууд нь хайгуул болон хөгжүүлэлт хийх боломжтой газрыг буцааж авах эсвэл худалдан авах; эсвэл
- ii) Хайгуул, үнэлгээний үйл ажиллагаа хийх боломжтой газар нь үнэлгээний эсвэл бусад эдийн засгийн нөхөн төлөгдөх баталгаагүй, нөөцийн шатандаа хараахан хүрээгүй мөн идэвхтэй, чухал үйл ажиллагаа тухайн талбайд үргэлжлээгүй эсвэл ирээдүйд төлөвлөгдөөгүй.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

е) Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж

Үндсэн хөрөнгө, үйлдвэр болон тоног төхөөрөмжийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлын зардлаар хэмждэг. Зардалд хөрөнгө авахтай шууд холбоотой өртгүүд багтана. Өөрөө барьж байгуулсан хөрөнгийн өртөгт: материалын өртөг, хөдөлмөрийн зардал болон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах нөхцөлийг бий болгоход шууд хамаарах бусад зардал багтдаг.

Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн элэгдлийг тооцоолохдоо тэдгээрийн зардал, үлдэх үнэ цэнийн цэвэр дүн, ашиглалтын тооцоолсон хугацааг хуваарилах бууралтын балансын аргаар тооцно:

<u>Хөрөнгө</u>	<u>Суурь</u>	<u>Хэмжээ</u>
Тээвэр, хээрийн хэрэгсэл	Буурах үлдэгдэл	30%
Тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил	Буурах үлдэгдэл	20%
Програм хангамж, компьютер	Буурах үлдэгдэл	33%

Шаардлагатай тохиолдолд элэгдлийн аргууд, ашиглалтын хугацаа, үлдэх үнэ цэнийн дүнг санхүүгийн жилийн төгсгөл тутамд хянаж тохируулна.

f) Түрээс

Гэрээ байгуулах үед Эрдэнэ Ресурс нь тухайн гэрээ нь түрээсийн талаар заалт, эсвэл тодорхой хугацаанд хөрөнгө эзэмших эрхийг шилжүүлж байгаа эсэхэд үнэлгээ хийдэг. Гэрээ нь байгуулагдсан цагаас эхлэн үл хөдлөх хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж болон санхүү тайлангийн урт хугацааны өр төлбөр дэх түрээстэй холбоотой өр төлбөр эзэмших эрх шилжих тохиолдолд түрээсийн гэрээ хэмээн авч үзнэ.

Хөрөнгө ашиглах эрхийг тооцоолохдоо түрээсийн өр төлбөрийг анх хэмжих үеийн зардал, эхлэх өдрөөс өмнө хийгдсэн аливаа төлбөр багтаж, хүлээн авсан түрээсийн урамшуулал, нөхөн сэргээх зардал болон анхны шууд өртгийг хасаж тооцно. Хөрөнгө ашиглах эрхийг түрээсийн хугацааны туршид шулуун-шугамын үндсэн дээр элэгдүүлэн тооцно.

Түрээсийн зохих өр төлбөрийг гэрээ хийгдсэн хугацааны үед төлөгдөөгүй түрээсийн өнөөгийн үнэ цэн, түрээсийн хүүгийн далд төлбөрөөр хөнгөлсөн эсвэл тухайн хувь хэмжээг тогтоох боломжгүй бол Эрдэнэ Ресурсийн зээлийн өрийн нэмэгдлийн хувь хэмжээ, зах зээлийн харьцуулалтад тулгуурлан тооцоолно.

Түрээсийн төлбөрт тогтмол төлбөрүүд, гэрээ хийгдсэн хугацааны үеийн индекс болон үнэлгээнээс хамааран хувьсах төлбөр, үлдсэн үнэ цэнийн баталгааны дагуу хүлээгдэж буй төлбөр, хэрэгжүүлэх боломжтой худалдах опцион хэрэгжүүлэх зэрэг багтана. Түрээсийн өр төлбөрийг зах зээлийн хүүгийн аргаар элэгдүүлсэн зардлаар тооцно.

Эрдэнэ Ресурс нь түрээсийг нягтлан бодох бүртгэлд дараах байдлаар тусгахаар зорилтуудыг тодорхойлсон.

- i) Салгах боломжтой бүрэлдэхүүн – Эрдэнэ Ресурс нь түрээсийн бус бүрэлдэхүүнийг түрээсийн бүрэлдэхүүнээс салгахгүй байхаар шийдсэн бөгөөд түрээсийн бүрэлдэхүүн болон түүнтэй холбогдох түрээсийн бус бүрэлдэхүүнийг нийтэд нь түрээсийн бүрэлдэхүүн хэмээн авч үзнэ.
- ii) Богино хугацааны түрээс – Эрдэнэ Ресурс нь 12 сар болон түүнээс бага хугацаатай түрээсийн чөлөөлөлтийг хүлээн зөвшөөрсөн.

g) Хувьцаанд суурилсан төлбөр

Ажилтнуудын урамшуулал болгон олгосон хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийг олгосон өдрийн бодит үнэ цэнээр Блэк Шолсийн үнэлгээний загварыг ашиглан тооцно. Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дүгнэлт (үргэлжлэл)

бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд тооцогддог.

Ажилтнуудын урамшууллаас бусад хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн гүйлгээ болон ижил төстэй урамшуулал, үйлчилгээ үзүүлж буйг зах зээлийн үнийг найдвартай тооцоолж чадахгүйгээс бусад тохиолдолд хүлээн авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн бодит үнээр хэмждэг.

h) Нэгж хувьцаанд ногдох алдагдал

Компани нь энгийн хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан нэгж хувьцааны алдагдлыг тайлагнадаг. Нэгж хувьцааны суурь алдагдлыг тооцоолохдоо энгийн хувьцаа эзэмшигчидтэй холбоотой ашиг болон алдагдлыг тухайн хугацаанд зах зээлд буй нийт хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан тооцно. Нэгж хувьцааны хорогдуулсан алдагдлыг энгийн хувьцаа эзэмшигчдийн тохируулсан ашиг болон алдагдлыг хорогдуулах боломжтой нийт энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулан, тохируулж тооцно. Бүх хувьцааны опцион нь өнөөгийн байдлаар хорогдуулах боломжит алдагдал орохгүй. Ингэснээр нэгж хувьцааны суурь болон хорогдуулах боломжит алдагдал нь адил хэмжээнд байна.

## 5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд болон тайлбарууд

2019 оны 1 дүгээр сарын 1-нээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

### СТОУС 16 - Түрээс

Компани нь 2019 оны 1-р сарын 1-нээс эхлэх санхүүгийн жилийн санхүүгийн тайлагналдаа СТОУС 16 стандартыг мөрдөж эхэлсэн. 2018 онд танилцуулсан мэдээлэл нь НББОУС-ын 17 стандартын дагуу танилцуулагдаж байсан.

Уг стандарт нь нягтлан бодох бүртгэлийн нэг түрээслэгчийн загварыг танилцуулсан ба үндсэн хөрөнгө нь бага өртөгтэй биш бол 12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг түрээслэгчид тавьдаг.

Компанийн оффисын түрээс, ажилтнуудын байрын түрээс зэрэг нь бүгд 12 сараас доош хугацаатай тул энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компани нь хөрөнгө ашиглах эрх, түрээсийн өр төлбөргүйг хүлээн зөвшөөрсөн.

Түрээслэгч нь түрээсэлсэн хөрөнгийг ашиглах эрхийг төлөөлсөн ашиглах эрхтэй хөрөнгийг ашиглах эрх, түрээсийн төлбөр төлөх үүргийг төлөөлсөн түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлага тавигддаг.

Компанийн төв оффисын түрээсийг таван жилээр хийсэн нь 2019 оны 9 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон. СТОУС 16 стандарттай холбоотой нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг Тодруулга 7-оос танилцана уу.

### СТОУТХ 23: Орлогын татварын тодорхойгүй байдал

2017 оны 6 сарын 7-нд СТОУТХ 23 Орлогын татварын бүртгэлийн тодорхойгүй байдал тайлбарыг НББОУС3-өөс гаргасан. Энэхүү тайлбарт орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхойгүй

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд болон тайлбарууд (үргэлжлэл)

байдал үүссэн тохиолдолд өнөөгийн болон хойшлогдсон татварын өр төлбөр, хөрөнгийг хэрхэн бүртгэх талаар тайлбарласан.

Компани нь одоогоор хойшлогдсон татварын өр төлбөр, хөрөнгө хүлээн зөвшөөрөөгүй тул СТОУТХ 23 нь санхүүгийн тайланд ямарваа нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.

*Мөрдөгдөж эхлээгүй байгаа нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд*

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг боловсруулахад ашиглаагүй дараах стандартууд нь ОУСББ-ын тайлант хугацааны дараа жилийн тайлангаас эхлэн мөрдөгдөх болно.

НББОУС 1 – Санхүүгийн тайлан бэлтгэх болон НББОУС 8 – Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба алдаа

2018 оны 10 сарын 31-ээс НББОУС 1 – Санхүүгийн тайлан бэлтгэх болон НББОУС 8 – Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба алдаа стандартуудад НББОУС3-өөс өөрчлөлт оруулсан. Энэ нь СТОУС-ын хүрээнд материаллаг байдлын тодорхойлолтыг тодорхой болгох зорилготой. Энэхүү өөрчлөлт нь 2020 оны 1 сарын 1-ээс эхлэх санхүүгийн жилээс мөрдөгдөж эхэлнэ. Энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт орохгүй гэж үзэж байна.

СТОУС 3 – Бизнесийн Нэгдэл

2018 оны 10 сарын 22-оос эхлэн СТОУС 3 Бизнесийн нэгдэл стандартад өөрчлөлт оруулсан ба бизнесийн тодорхойлолтыг нарийвчлах, шалгалтыг нэвтрүүлэх зорилготой, энэ нь тодорхой тохиолдолд нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагагүй болгоно. Энэхүү өөрчлөлт нь 2020 оны 1 сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлснээр Компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй.

## 6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

	Хөндий Алтны Төсөл	Зуун Мод Моли/Зэс	Улаан ба бусад	Нийт
2018.01.01 үлдэгдэл	\$ 9,700,832	\$ 765,795	\$ 928,216	\$ 11,394,843
Нэмэгдэл	4,291,555	70,074	1,388	4,363,017
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(62,077)	(4,143)	(4,292)	(70,512)
2018.12.31 үлдэгдэл	\$ 13,930,310	\$ 831,726	\$ 925,312	\$ 15,687,348
2019.01.01 үлдэгдэл	\$ 13,930,310	\$ 831,726	\$ 925,312	\$ 15,687,348
Нэмэгдэл	6,735,135	67,091	1,902	6,804,128
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(897,504)	(70,018)	(40,437)	(1,007,959)
2019.12.31 үлдэгдэл	\$ 19,767,941	\$ 828,799	\$ 886,777	\$ 21,483,517

Компанийн Монгол улс дахь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Компанийн охин компаниуд болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорзис ХХК, Лидер Эксплорэйшн ХХК эзэмшдэг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

Хөндий Алтны Төсөл

Хөндий Алтны Төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт, 2,309 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, 2,205 га Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай болон алт, мөнгө, цайр, хар тугалгын нөөц бүхий Алтан Нар ордыг агуулсан 4,669 га Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

хамарч оршдог. 2018 оны 9 сарын 30-аас өмнө Цэнхэр Номин, Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн хайгуул болон үнэлгээг тусдаа тайлагнаж байсан. 2018 оны сүүлээр энэхүү тусгай зөвшөөрлүүдийг хамтад нь хөгжүүлж, хайгуул, үнэлгээний хөрөнгө, зардлуудыг хамтад нь тайлагнах болсон.

2019 оны 8 сарын 5-нд Монгол улсын Ашигт Малтмал Газрын Тосны Газар (“АМГТГ”)-аас Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэсгийг ашиглалтын тусгай зөвшөөрөл болгосон. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Тетра Тек-ийн боловсруулж, 2018 оны 12 сарын 4-нд танилцуулсан “Khundii Gold Project, NI 43-101 Technical Report” нэртэй тайлан дахь Баян Хөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрөлд Эрдэнэ Ресурсийн Хар Морь, Алтан Сум, Хойд Хөндий, Баруун Хөндий зэрэг хэтийн төлөв бүхий талбай багтаж байна.

Хөндий тусгай зөвшөөрлийн талбайгаас 2,205 га талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжээгүй, хайгуулын тусгай зөвшөөрөл хэвээр байна. Энэхүү хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 10 дахь жилдээ хүчинтэй байгаа бөгөөд 12 жилийн хугацаа дуусахаас өмнө Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой.

Компани нь 2016 оны 7 сарын 1-ээс капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Үүнээс өмнө зөвхөн Баян Хөндий тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

2020 оны 3 сарын 5-нд Ашигт Малтмал Газрын Тосны Газар Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон бүртгэсэн. 2015 оны 1 сарын 1-нд Алтан Нарын анхан шатны нөөцийн тооцооллыг гүйцэтгэсэн бөгөөд Компани нь капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Компани нь 2015 оноос өмнө зөвхөн Алтан Нартай холбоотой тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

### Зуун Мод/ Хөвийн Хар

Зуун Мод төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт байрладаг. 6,041 га талбайг хамарсан тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд авсан бөгөөд энэхүү тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаанд хүчинтэй, цаашид 20 жилийн хугацаатайгаар 2 удаа сунгах боломжтой.

Молибденийн зах зээлийн үнэ нэмэгдэх үед Зуун Мод зэс-молибденийн төслийг хөгжүүлэх боломжтой бөгөөд Компани нь технологи ба зах зээлийн хүчин зүйлсийг магадлан, судална.

### Улаан ба бусад

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай хил залгаа, нийт 1,780 га талбайг хамардаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн дахь жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу цаашид 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой. 2017 оны 8 сарын 30-нд Эрдэнэ Ресурс нь Лидер Эксплорэйшн ХХК (Монгол улсын)-ийн 51%-ийг худалдаж авсан. Эрдэнэ Ресурс нь СТОУС 3-ийн дагуу үнэлгээ гаргасан бөгөөд үнэлгээгээр энэхүү гэрээ хэлцэл нь хөрөнгө худалдан авах ангилалд багтана (бизнес худалдан авах бус) гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Эрдэнэ Ресурс нь 2020.8.30 хүртэл \$600,000 ам.долларын хайгуулын ажил гүйцэтгэснээр Лидер Эксплорэйшн ХХК-ийн үлдсэн 49%-ийг зах зээлийн үнээр худалдан авах эрх үүснэ.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

2019 оны 12 сарын 31-ний байдлаар хайгуулын ажлыг хийж гүйцэтгэх нөхцөлийг биелүүлснээр үлдсэн хувьцааг авах эрх үүссэн. Компани жилд \$100,000-ыг хайгуул судалгаанд зарцуулснаар дээрх эрхийг сунгах боломжтой.

2013 оны 4 сард Монгол улсын баруун өмнөд хэсгийн Транс-Алтайн бүс нутагт Компанийн хайгуулын ажлыг санхүүжүүлэх, хамтран ажиллах зорилгоор Тек Ресорсиз Лимитед компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд 2015 оны эхээр 1,552 га талбайг хамарсан хоёр тусгай зөвшөөрлийн талбайг санхүүжүүлсэн. Одоогоор эдгээр тусгай зөвшөөрлийн талбайд томоохон хэмжээний хайгуулын ажил хийгдээгүй байна.

## 7. Түрээс, гэрээгээр хүлээсэн үүрэг

Компани нь 2019 оны 9 сарын 1-ээс эхлэн 5 жилийн оффисын түрээсийн гэрээ хийсэн. Энэхүү түрээс нь баланс дээр түрээсийн өр төлбөр, хөрөнгө ашиглах эрх болон танилцуулсан. Түрээсийн хөнгөлөлт 7%-аар тооцсон.

Хөрөнгө ашиглах эрхийн талаар нэмэлт мэдээлэл:

	Нэмэгдэл	Элэгдэл	Дансны дүн
Оффис	\$ 146,854	\$ (9,790)	\$ 137,064

2019 оны 12 сарын 31-ний байдлаар төв оффисын түрээсийн өр төлбөрийн хугацаа дуусах тухай:

	1 жилийн дотор	1 - 2 жил	2 - 3 жил	3 - 4 жил	Нийт
Түрээсийн төлбөр	\$ 34,480	\$ 34,522	\$ 34,693	\$ 58,395	\$ 162,090
Санхүүгийн зардлууд	(8,783)	(6,669)	(4,553)	(2,835)	(22,840)
<b>Нийт төлбөр</b>	<b>\$ 25,697</b>	<b>\$ 27,853</b>	<b>\$ 30,140</b>	<b>\$ 55,560</b>	<b>\$ 139,250</b>

Компанийн Монгол улс дахь оффис болон ажилтнуудын байрны түрээс нь 12 сарын дотор хугацаа дуусна. Компани нь энэхүү байгууламжуудын түрээсийн төлбөрийг гүйцэтгэснээр зарлагадсан. Компани нь СТОУС 16-ын шаардлагыг эдгээр төлбөрт тусгахгүй байхаар шийдсэн бөгөөд түрээсийн төлбөрийг зарлагадснаар бүртгэсэн.



# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 8. Үндсэн хөрөнгө, үйлдвэр тоног төхөөрөмж

	Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
<b>Зардал</b>				
2018.01.01 үлдэгдэл	\$ 98,105	\$ 107,674	\$ 195,958	\$ 401,737
Нэмэгдэл	-	3,497	12,580	16,077
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(233)	(110)	(189)	(532)
<b>2018.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ 97,872</b>	<b>\$ 111,061</b>	<b>\$ 208,349</b>	<b>\$ 417,282</b>
<b>Элэгдэл ба хорогдол</b>				
2018.01.01 үлдэгдэл	\$ (11,365)	\$ (78,076)	\$ (182,013)	\$ (271,454)
Элэгдэл	(9,938)	(4,463)	(6,503)	(20,904)
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	178	103	72	353
<b>2018.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ (21,125)</b>	<b>\$ (82,436)</b>	<b>\$ (188,444)</b>	<b>\$ (292,005)</b>
<b>Дансны дүн</b>				
2018.01.01-нд	\$ 86,740	\$ 29,598	\$ 13,945	\$ 130,283
2018.12.31-нд	\$ 76,747	\$ 28,625	\$ 19,905	\$ 125,277
	Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
<b>Зардал</b>				
2019.01.01 үлдэгдэл	\$ 97,872	\$ 111,061	\$ 208,349	\$ 417,282
Нэмэгдэл	-	100	10,553	10,653
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(7,691)	(3,721)	(2,075)	(13,487)
<b>2019.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ 90,181</b>	<b>\$ 107,440</b>	<b>\$ 216,827</b>	<b>\$ 414,448</b>
<b>Элэгдэл ба хорогдол</b>				
2019.01.01 үлдэгдэл	\$ (21,125)	\$ (82,436)	\$ (188,444)	\$ (292,005)
Элэгдэл	(9,431)	(4,466)	(8,561)	(22,458)
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	2,073	2,184	1,756	6,013
<b>2019.12.31 үлдэгдэл</b>	<b>\$ (28,483)</b>	<b>\$ (84,718)</b>	<b>\$ (195,249)</b>	<b>\$ (308,450)</b>
<b>Дансны дүн</b>				
2019.01.01-нд	\$ 76,747	\$ 28,625	\$ 19,905	\$ 125,277
2019.12.31-нд	\$ 61,698	\$ 22,722	\$ 21,578	\$ 105,998

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 9. Гэрээгээр хүлээсэн үүрэг

2020 онд Алтан Нар, Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын зардалд хамгийн багадаа \$10/га ам.долларыг зарцуулах нөхцөлтэй (тус бүр \$46,690, \$22,050 ам.доллар). Эрдэнэ Ресурс нь гурван жилийн хугацаанд \$600,000 ам.долларын хайгуулын ажил гүйцэтгэх нөхцөлийг биелүүлснээр, 2019 оны 12 сарын 31-ний байдлаар Лидер Эксплорэйшн ХХК (Улаан)-ийн үлдсэн 49%-ийг зах зээлийн үнээр худалдан авах эрх үүссэн. Жилд \$100,000 ам.долларын хайгуулын ажлыг гүйцэтгэснээр 49%-ийг худалдан авах хугацааг сунгах боломжтой. (Тодруулга 6-аас харна уу.)

2016 оны 4 сарын 21-нд Компани нь Цэнхэр Номин ба Хөндий тусгай зөвшөөрлийн хүрээнд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндстормд төлөх үүрэг хүлээсэн. 2019 оны 4 сарын 12-нд Эрдэнэ Ресурс нь дээрх NSR-ын 50%-ийг \$1.2 сая доллараар худалдан авч, 1% болгон бууруулсан. Сэндсторм нь Хөндий болон Цэнхэр Номин тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой давуу эрх эдлэх нөхцөлтэй.

Галлант Минералс Лимитед нь Зуун Мод тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR хүлээн авах эрхтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажил гүйцэтгэх үүрэг хүлээгээгүй.

## 10. Хөрвөх нөхцөлтэй зээлийн тухай

2019 оны 10 сарын 11-нд Эрдэнэ Ресурс нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("EBRD")-аас 5 сая ам.доллар (6.6 сая кан.доллар)-ын санхүүжилт авсан. Анхны санхүүжилтийн 2.5 сая ам.долларын гүйлгээ 2019 оны 11 сарын 4-нд, хоёр дахь санхүүжилт болох 2.5 сая ам.долларын гүйлгээ 2019 оны 11 сарын 25-нд хийгдсэн.

Хөрвөх зээлийн үндсэн нөхцөлүүд;

- Үндсэн дүн 5.0 сая ам.доллар
- Эрдэнэ Ресурсийн сонголтоор хагас жил тутамд бэлэн мөнгө эсвэл өөр хэлбэрээр төлөх 10%-ийн хүү
- 2022 оны 10 сард хугацаа дуусна
- Холбогдох нөхцөлүүдийг хангаснаар нэг, хоёр, гурван жилийн хугацаанд нэгж хувьцааг \$0.20 канад доллараар үнэлж, жил тус бүр 10%, 20% болон 30%-ийн нэмэгдэл үнэлгээтэйгээр EBRD-ийн сонголтоор хэсэгчлэн болон бүтнээр компанийн Энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой.
- Хөрвөх үнэ нь нэг, хоёр, гурван жилийн хугацаанд 10%, 20%, 30%-ийн нэмэгдэл үнэлгээтэйгээр хөрвөх өдрөөс өмнө 5 өдрийн жигнэсэн дундаж ханш байна.
- Зээлийг дараах хоёр нөхцөлийн аль нэг нь бүрдсэний дараа 25%-ийн нэмэгдэлтэйгээр эргүүлэн төлж болно, үүнд: (1) NI 43-101 стандартын дагуу хийгдсэн эцсийн ТЭЗҮ-ийг бүртгүүлэх эсвэл Эрдэнэ Ресурсийн хяналтын багц солигдох (2) анхны санхүүжилтийн гүйлгээ хийгдсэнээс хойш 24 сар өнгөрсөн тохиолдолд.

Компанийн төслүүдийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компанийн хувьцаа нь зээлийн баталгаа болно.

Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор Зээл нь холимог санхүүгийн хэрэглүүрт орох ба үүнд: зээлийн үндсэн үүрэг, хөрвүүлэлт ба урьдчилгаа төлбөрийн шинж чанаруудыг багтаасан үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орно. Компани нь зээлийн үүргийг зээлийн хугацааны эцэс хүртэл хуримтлагдсан өртгөөр тооцно. Хөрвүүлэлт ба урьдчилгаа төлбөрийн опционыг ашиг эсвэл алдагдлын бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр болгон тооцно.

Зээл олгосон өдөр зээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бодит үнэ цэнээр үнэлснийг доорх хүснэгтэд харуулав:

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 10 Хөрвөх нөхцөлтэй зээлийн тухай (үргэлжлэл)

	12 сарын 31 2019	
Олгосон өдрийн өр төлбөрийн бүрэлдэхүүн	\$	4,505,902
Олгосон өдрийн хөрвүүлэлт, урьдчилан төлөх опцион		2,106,123
Санхүүгийн зардал		(254,262)
Цэвэр орлого	\$	6,357,763

2019.12.31-ний байдлаар өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт орсон өөрчлөлт:

	12 сарын 31 2019	
Олгосон өдрийн өр төлбөрийн бүрэлдэхүүн	\$	4,505,902
Бага: Санхүүгийн хойшлогдсон зардал		(254,262)
Зээлийн нөхцлөөр капиталжуулах хугацааны зээлийн хүүгийн зардал		162,051
Валютын ханшийн хөдөлгөөний нөлөө		(80,321)
2019.12.31 үлдэгдэл	\$	4,333,370

Хөрвөх опционыг бодит үнэ цэнээр бүртгэсэн ба 2019.12.31-ний байдлаар үнэ цэнийг биномын опционы үнэлгээний загварт тулгуурлан, дараах үндсэн төсөөллүүдийг ашиглан тодорхойлсон. Үүнд: 65% хэлбэлзэл, 1.6% эрсдэлгүй хүүгийн хэмжээ, 2.8 жилийн хөрвөх опционы хугацаа багтсан.

	12 сарын 31 2019	
Олгосон өдрийн хөрвүүлэлт	\$	2,106,123
Бодит үнэ цэнийн тохируулга		(143,124)
Валютын ханшийн хөдөлгөөний нөлөө		(35,848)
2019.12.31 үлдэгдэл	\$	1,927,151

## 11. Орлогын татвар

Доорх нөхцөл байдлаас шалтгаалан Компанийн орлого (алдагдал)-д ногдуулах бодит татварын хувь хэмжээ нь Канад улсын холбооны болон мужийн татваруудын нийлмэл хувь хэмжээнээс зөрүүтэй тооцоологдохоор байна:

	12 сарын 31 2019		12 сарын 31 2018	
Албан татварын хувь хэмжээ		31%		31%
Албан татварын хувь хэмжээгээр тооцсон орлогын татвар (нөхөгдөх)	\$	(832,000)	\$	(1,134,000)
Түр хугацааны тооцогдоогүй зөрүүгийн ашиг		439,000		551,000
Татварын зорилгоор хасагдах боломжгүй зардлууд		239,000		384,000
Гадаад улсын татварын хувь хэмжээний нөлөө		154,000		199,000
Олгосон татварын орлого	\$	-	\$	-

Татварын хувь хэмжээг татварын тооцоололдоо ашиглахад: Канад улсад 31% (2018 онд 31% байсан), Монгол улсад 25% (2018 онд 25% байсан).

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 11 Орлогын татвар (үргэлжлэл)

	12 сарын 31 2019	12 сарын 31 2018
Урагшлуулсан хөрөнгийн бус алдагдал	80,000	-
Хойшлуулсан орлогын татварын хөрөнгө	80,000	-
Хөрвөх нөхцөлтэй зээл	(80,000)	-
Хойшлуулсан цэвэр орлогын татварын хөрөнгө (өр төлбөр)	\$ -	\$ -

Дараах түр хугацааны зөрүү, хөрөнгийн бус алдагдлууд болон хөрөнгийн алдагдлуудыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй болно.

	2018.12.31		
	Канад улс	Монгол улс	Нийт
Хөрөнгийн бус алдагдал	\$ 16,845,000	\$ 1,694,000	\$ 18,539,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж	228,000	-	228,000
Хувьцаа гаргасан зардал	1,305,000	-	1,305,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	5,737,000	8,885,000	14,622,000
	\$ 24,493,000	\$ 10,579,000	\$ 35,072,000

	2019.12.31		
	Канад улс	Монгол улс	Нийт
Хөрөнгийн бус алдагдал	\$ 18,472,000	\$ 1,683,000	\$ 20,155,000
Үндсэн хөрөнгө, үйлдвэр тоног төхөөрөмж	239,000	-	239,000
Хувьцаа гаргасан зардал	1,248,000	-	1,248,000
Биет бус хөрөнгө	378,000	-	378,000
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	5,737,000	8,574,000	14,311,000
	\$ 26,074,000	\$ 10,257,000	\$ 36,331,000

2019 оны 12 сарын 31-ний байдлаар Компани ирээдүйд шилжүүлэн татвар ногдох орлого хорогдуулах хөрөнгийн бус алдагдлууд үүссэн. Энэхүү алдагдлуудаар татвар ногдох орлого хорогдуулах хугацааг доор үзүүлэв:

	12 сарын 31 2019	12 сарын 31 2018
2019	-	333,000
2020	353,000	381,000
2021	438,000	473,000
2022	469,000	507,000
2023	423,000	
Түүнээс хойш	18,729,000	16,845,000
	\$ 20,412,000	\$ 18,539,000

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

## 12. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

### Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

### Гаргасан хувьцаа

2019 оны 2 сарын 28-нд Компани нь нийт \$2,533,345 долларын санхүүжилтийг хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн. Нийт 11,014,544 ширхэг хувьцааны нэгж тус бүрийг \$0.23 кан.доллараар үнэлсэн. Эдгээр хувьцааны нэгж тус бүр нь нэг энгийн хувьцаа болон энгийн хувьцаа худалдан авах нэг варрантаас бүрдэнэ. Варрантыг санхүүжилт хаагдсанаас хойш нэг жилийн хугацаанд 12 сарын дотор нэгж хувьцааг \$0.40, түүнээс дээш хугацаанд \$0.50 үнэлгээтэйгээр хэрэгжүүлэх боломжтой. Компани нь зуучлалын үйлчилгээний хураамжид \$62,116 болон 270,070 ширхэг варрантыг төлсөн. Түүнээс гадна санхүүжилттэй холбоотой зардалд \$38,107 төлж, нийт \$2,433,122 орлого төвлөрүүлсэн.

2019 оны 7 сарын 9-нд Компани нь нийт \$2,001,500 кан.долларын санхүүжилтийг хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн. Компани нь нийт 10,007,500 ширхэг хувьцааны нэгж тус бүрийг \$0.20 кан.доллараар үнэлсэн. Эдгээр хувьцааны нэгж тус бүр нь нэг энгийн хувьцаа болон энгийн хувьцаа худалдан авах хагас (½) варрантаас бүрдэнэ. Варрантыг санхүүжилт хаагдсанаас хойш хоёр жилийн хугацаанд нэгж тус бүрийг \$0.30 кан.доллараар хэрэгжүүлэх боломжтой. Эрдэнэ Ресурс нь зуучлалын үйлчилгээний хураамжинд \$35,860 болон 108,800 ширхэг варрантыг төлсөн. Түүнээс гадна санхүүжилттэй холбоотой зардалд \$38,589 төлж, нийт \$1,927,051 орлого төвлөрүүлсэн.

2019 оны 11 сарын 29-нд Компани нь нийт \$980,000 кан.долларын санхүүжилтийг хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн. Нийт 4,900,000 ширхэг хувьцааны нэгж тус бүрийг \$0.20 кан.доллараар үнэлсэн. Эдгээр хувьцааны нэгж тус бүр нь нэг энгийн хувьцаа болон хагас варрант (½)-аас бүрдэнэ. Варрантыг санхүүжилт хаагдсанаас хойш хоёр жилийн хугацаанд тус бүрийг \$0.30 кан.доллараар хэрэгжүүлэх боломжтой. Эрдэнэ Ресурс нь зуучлалын үйлчилгээний хураамжинд \$18,200 болон 91,000 ширхэг варрантыг төлсөн. Түүнээс гадна санхүүжилттэй холбоотой зардалд \$12,110 төлж, нийт \$949,690 орлого төвлөрүүлсэн.

### Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("DSU")

Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийг Компани 2013 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнуудыг урамшуулах хувьцааны опционы төлөвлөгөөтэй адил урт хугацааны хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ирээдүйд олгогдох хувьцааны нэгжийн тоо ширхэг хугацааг ТУЗ тодорхойлох бөгөөд дээрх эрхийг нөхөн төлбөр, урамшуулал болгох эсэхийг мөн тодорхойлно. Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ.

2019 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нэгж тус бүрийг дунджаар \$0.20 кан.доллараар үнэлсэн 2,297,762 ширхэг ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон (2018 – \$0.31 кан.доллараар үнэлэгдсэн 543,932 ширхэг олгосон). Бодит үнэлгээ нь \$462,010 кан.доллар (2018 – \$166,894) бүхий ирээдүйд

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 12. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

олгогдох хувьцааны эрх нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан. 2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцэст Эрдэнэ Ресурс нь ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн төлөвлөгөөнөөс нэгж бүр нь \$0.18 кан.долларын үнэлгээ бүхий 1,615,030 хувьцааг гаргасан (2018 – nil).

	2019.12.31-нд дуусгавар болсон	2018.12.31-нд дуусгавар болсон
Олгогдох өдрөөс тооцоолсон 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.20	\$ 0.31

2018, 2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тухай мэдээлэл:

	2019.12.31 Тоо ширхэг	2018.12.31 Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	3,954,118	3,410,186
Олгосон	2,297,762	543,932
Гаргасан	(1,615,030)	-
12 сарын 31-ний байдлаар	4,636,850	3,954,118

### Варрант

2019 оны 2 сарын 28-нд нийт 11,284,614 ширхэг варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан бөгөөд санхүүжилт хаагдсанаас хойш нэг жилийн хугацаанд 12 сарын дотор нэгж хувьцааг нэгж хувьцааг \$0.40, түүнээс дээш хугацаанд \$0.50 кан.доллараар хэрэгжүүлэх боломжтой. Варрантын хугацаа 2021 оны 2 сарын 28-нд дуусна.

2019 оны 7 сарын 9-нд нийт 5,112,550 ширхэг варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан бөгөөд санхүүжилт хаагдсанаас хойш нэг жилийн хугацаанд 24 сарын дотор нэгж хувьцааг нэгж хувьцааг \$0.30 кан.доллараар хэрэгжүүлэх боломжтой. Варрантын хугацаа 2021 оны 7 сарын 9-нд дуусна.

2019 оны 10 сарын 25-нд нийт 1,906,000 ширхэг варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан бөгөөд санхүүжилт хаагдсанаас хойш нэг жилийн хугацаанд 24 сарын дотор нэгж хувьцааг \$0.30 кан.доллараар хэрэгжүүлэх боломжтой. Варрантын хугацаа 2021 оны 10 сарын 25-нд дуусна.

2019 оны 11 сарын 29-нд нийт 635,000 ширхэг варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан бөгөөд санхүүжилт хаагдсанаас хойш нэг жилийн хугацаанд 24 сарын дотор нэгж хувьцааг нэгж хувьцааг \$0.30 кан.доллараар хэрэгжүүлэх боломжтой. Варрантын хугацаа 2021 оны 11 сарын 29-нд дуусна.

2019 оны 2 сарын 22-нд нийт 1,075,324 варрантын хугацаа дууссан.

Доорх хүснэгтэд 2018 болон 2019 оны 12 сарын 31-ний байдлаар варрантын мэдээллийг үзүүлэв:

	2019.12.31		2018.12.31	
	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
1 сарын 1-ний байдлаар	12,389,904	\$ 0.65	1,075,324	\$ 1.20
Гаргасан	18,938,164	0.39	11,314,580	0.60
Хэрэгжсэн	(1,075,324)	1.20	-	-
12 сарын 31-ны байдлаар гаргасан	30,252,744	\$ 0.47	12,389,904	\$ 0.65
12 сарын 31-ны байдлаар хэрэгжих боломжтой	30,252,744	\$ 0.47	-	\$ 0.65

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 12. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

2019 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжих боломжтой варрантын мэдээлэл

Хэрэгжүүлэх үнэ	Варрантын тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)
\$0.30	7,653,550	1.63
\$0.40 - \$0.50	11,284,614	1.16
\$0.60	11,314,580	0.94
	<b>30,252,744</b>	<b>1.20</b>

### Хувьцаанд суурилсан нөхөн олговор

2019 оны 12 сарын 31-ний байдлаар Компани нь \$703,060 (2018 – \$1,186,004) кан.долларыг хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн нэгтгэсэн алдагдалд зарлагдсан, үүнээс \$230,292 (2018 – \$473,150) кан.долларыг хайгуулын зардалд тооцсон.

### Хувьцааны опцион

Компани тогтмол 10%-ийн опционы урамшууллын хөтөлбөр (“Хөтөлбөр”) хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнууд компанийн хувьцааг худалдан авах опционыг худалдан авч, хэрэгжүүлэх боломжтой. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опционыг олгохдоо нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн шууд хэрэгжүүлэх боломжтой. Төлөвлөгөөний хүрээнд энгийн хувьцааны хувьд олгох опцион нь Компанийн гаргасан болон зах зээлд буй энгийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байх ба опционыг олгох шийдвэр гаргах үед нэг хүнд 5%-аас илүү олгох эрхгүй (хорогдуулахгүй байдалд үндэслэдэг).

2019 оны 12 сарын 31-ний байдлаар жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ нь \$0.20 кан.доллар бүхий 2,670,000 опционыг олгосон. Мөн жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ нь \$0.15 кан.доллар бүхий 1,105,000 опционыг хэрэгжүүлж, \$169,800 орлого олсон. 2019 оны 12 сарын 31-ний байдлаар 595,000 ширхэг опционы хугацаа дууссан (2018 – 100,000 опцион).

2018, 2019 оны 12 сарын 31-ний байдлаар үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

	2019.12.31		2018.12.31	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ
1 сарын 1-ний байдлаар	11,335,000	\$ 0.43	9,703,750	\$ 0.40
Олгосон	2,670,000	0.20	3,360,000	0.39
Хугацаа дууссан	(595,000)	0.42	(100,000)	0.40
Хэрэгжүүлсэн	(1,105,000)	0.15	(1,628,750)	0.16
12 сарын 31-ний байдлаар	<b>12,305,000</b>	<b>\$ 0.41</b>	<b>11,335,000</b>	<b>\$ 0.43</b>
12 сарын 31-ний байдлаар хэрэгжих боломжтой	<b>12,305,000</b>	<b>\$ 0.41</b>	<b>11,335,000</b>	<b>\$ 0.43</b>

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 12. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

2018 болон 2019 онд олгосон бүх опцион нь таван жилийн хугацаанд, шууд хэрэгжүүлэх боломжтой опцион юм. Доорх хүснэгтэд 2019 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлэх боломжтой бүх гаргасан опционын мэдээллийг харуулав.

Дуусах хугацаа	2019.12.31		2018.12.31	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ
08/01/2019	-	\$ -	325,000	\$ 0.14
18/06/2019	-	-	935,000	0.16
05/06/2020	1,050,000	0.15	1,100,000	0.15
02/07/2020	100,000	0.15	100,000	0.15
22/12/2020	855,000	0.16	895,000	0.16
15/06/2021	1,825,000	0.36	1,950,000	0.36
31/03/2022	2,445,000	0.87	2,620,000	0.87
18/07/2022	150,000	0.89	150,000	0.89
04/02/2023	50,000	0.50	50,000	0.50
13/03/2023	100,000	0.40	100,000	0.40
14/06/2023	2,785,000	0.40	2,810,000	0.40
15/10/2023	150,000	0.27	150,000	0.27
08/11/2023	150,000	0.24	150,000	0.24
20/06/2024	2,495,000	0.20	-	-
29/11/2024	100,000	0.18	-	-
20/12/2024	50,000	0.18	-	-
	<b>12,305,000</b>	<b>\$ 0.41</b>	<b>11,335,000</b>	<b>\$ 0.43</b>

Гаргасан опцион бүрийн үнэ цэнийг опцион гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан, жигнэсэн дундаж үнээр тогтоосон.

	2019.12.31		2018.12.31	
Гаргах өдрийн хувьцааны үнэ	\$	0.19	\$	0.49
Хэрэгжүүлэх үнэ	\$	0.20	\$	0.39
Эрсдэлгүй хүүгийн түвшин		1.4%		2.0%
Хүлээгдсэн хугацаа		3.8 жил		4.0 жил
Хүлээгдсэн хэлбэлзэл		63%		77%
Хүлээгдсэн ногдол ашиг		0.0%		0.0%
Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ	\$	0.09	\$	0.30

Хүлээгдсэн хэлбэлзлийг үнэт цаасны түүхэн ханшийн хэлбэлзлийг харгалзан тооцсон.

2019 онд гаргасан опцион нь хувьцаанд суурилсан нөхөн төлбөр ба захиргааны зардалд \$241,05 (2018 – \$1,019,110) кан.долларын зардал хэлбэрээр тусгагдсан.

Дараах хүснэгтэд 2019 оны 12 сарын 31-ний байдлаар хэрэгжүүлж болох опционы хугацааг харуулав.

Үнэ	Хэрэгжүүлэх боломжтой опционы тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)	Хэрэгжүүлэх боломжтой опционы жигнэсэн дундаж үнэ
\$0.14 - \$0.24	4,800,000	2.88	\$ 0.18
\$0.25 - \$0.49	4,860,000	2.71	0.38
\$0.50 - \$0.89	2,645,000	2.28	0.86
	<b>12,305,000</b>	<b>2.68</b>	<b>\$ 0.41</b>



# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 13. Хайгуул болон үнэлгээний зардал

2018, 2019 оны 12 сарын 31-ний байдлаар хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав.

	12 сарын 31	
	2019	2018
Элэгдэл хорогдол	\$ 14,224	\$ 14,733
Шууд зардал	650,482	811,155
Ажилтан, албан тушаалтнуудын нөхөн олговор	195,788	296,637
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	230,292	473,150
	\$ 1,090,786	\$ 1,595,675

## 14. Захиргаа, удирдлагын зардал

2018, 2019 оны 12 сарын 31-ний байдлаар захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг дор харуулав.

	12 сарын 31	
	2019	2018
Захиргааны үйлчилгээ	\$ 373,799	\$ 535,118
Элэгдэл, хорогдол	18,051	6,194
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, нөхөн төлбөр	178,409	132,841
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	109,963	201,074
Оффис, бусад	107,841	123,271
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	202,576	236,394
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардлууд	105,234	116,567
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	472,768	712,854
Томилолтын зардал	47,083	56,077
	\$ 1,615,724	\$ 2,120,390

## 15. Санхүүгийн хэрэглүүр

### Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдлийг агуулдаг. Тайлангийн өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл хамгийн их хүлээж буй хөрөнгийг харуулбал:

	Дансны дүн	
	12.31 2019	12.31 2018
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 5,106,863	\$ 1,748,249
Авлага	70,361	113,412
	\$ 5,177,224	\$ 1,861,661

Компани нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канад улсын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудад байршуулж, зээлийн эрсдэлээ удирддаг. Ингэснээр алдагдлыг хамгийн бага хэмжээнд байлган, эрсдэлийг бууруулна гэж Компани үздэг. 2019 оны 12-р сарын 31-ний байдлаарх бэлэн мөнгөний үлдэгдлийн 1% буюу \$60,511 кан.долларыг Канад улсаас гадуурх банкуудад байршуулсан. (2018 - \$66,342, 4%).

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

## 15. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

### Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

Компани нь 2020 онд төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд тайланд тусгагдсан эргэлтийн хөрөнгө хүрэлцэхгүй бөгөөд дахин санхүүжилт татан төвлөрүүлэх шаардлагатай. (Тодруулга 2-оос танилцана уу.)

### Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

#### а) Хүүгийн эрсдэл

2019 оны 12 сарын 31-ний байдлаар Компанийн хөрвөх нөхцөлтэй зээл нь 10%-ийн тогтмол хүү тооцогдох тул хүүгийн өөрчлөлтийн эрсдэлд өртөхгүй болно.

#### б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь Канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь Монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь Америк доллараар санхүүжилт авч, зардлыг гаргасан. Иймээс Канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, Монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад улсын банкуудад канад болон ам.доллар байршуулдаг.

Мөн Компани нь хөрвөх нөхцөлтэй өр төлбөртэй холбоотойгоор ам.долларын валютын ханшийн эрсдэлд орох магадлалтай. Хугацаа дуусахад \$5 сая ам.долларын үндсэн төлбөр, капиталжуулсан хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дуусна. Иймд, Компанид Канад/Америк долларын ханшийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэл үүсэх тул хөрвөх нөхцөлтэй өр төлбөрийг барагдуулахад илүү зардал гарах магадлалтай.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав.

	12.31 2019	12.31 2018
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 4,854,316	\$ 96,157
Худалдаа, бусад авлага	-	-
Худалдаа, бусад төлөгдөх	(155,219)	(24,244)
Хөрвөх нөхцөлтэй зээл	(1,927,151)	-
	\$ 2,771,946	\$ 71,913

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$277,200 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (December 31, 2018 - \$7,200).

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

Компанийн гадаад валют (төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав.

## 15. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

	12.31 2019	12.31 2018
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 7,963	\$ 3,432
Худалдаа, бусад авлага	5,877	7,218
Худалдаа, бусад төлөгдөх	(69,501)	(22,159)
	\$ (55,661)	\$ (11,509)

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$5,600 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (December 31, 2018 - \$1,200).

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

### Бодит үнэ цэн:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, тодруулгад тусгагдсан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход бодит үнэ цэнийн ач холбогдлыг тусгасан шатлал ашигладаг. Үүнд:

Түвшин1: Идэвхтэй зах зээлд нэг төрлийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн өгөгдөл нь тогтоосон үнэтэй байна.

Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн тогтоосон үнийн 1-р түвшинд багтсан үнээс бусад өгөгдөл шууд (жишээ нь үнэ) эсвэл шууд бус (жишээ нь үнээс гаралтай)

Түвшин 3: Өгөгдөл нь хэмжиж болохуйц бус (зах зээлийн үйл ажиллагаа бага, эсвэл огт дэмждэггүй) байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн шатлалыг санхүүгийн тайлангийн тодруулгад дараах байдлаар тусгасан. Үүнд:

	2019.12.31			2018.12.31		
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө:						
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 5,106,863	\$ -	\$ -	\$ 1,748,249	\$ -	\$ -
Авлага	-	70,361	-	-	113,412	-
Хөрвөх нөхцөлтэй зээл	-	(1,927,151)	-	-	-	-

## 16. Холбогдох талууд

Компанийн голлох удирдлагын ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

	12 сарын 31	
	2019	2018
ТУЗ-ийн гишүүдийн цалин	\$ 161,977	\$ 111,500
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	245,700	343,600
Ажилтнуудын цалин, урамшуулал	470,746	386,892
Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	245,306	440,573
	\$ 1,123,729	\$ 1,282,565

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга  
(Канад доллараар)

2018 болон 2019 оны 12 сарын 31-ний жилийн эцэст

---

2019 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Компанийн тодорхой ажилтнууд, гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүд богино хугацааны урьдчилгааг хүлээн авсан. 2019 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон хугацаанд урьдчилгаа төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.

## 17. Тайлант хугацаанаас хойш өрнөсөн үйл явдлууд

2020 оны 3 сарын 5-нд Компани нь Ашигт Малтмал, Газрын Тосны Газраас Алтан Нар төсөл дээр MV-021547 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан. Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд 70 жил хүртэл сунгах боломжтой.

*Орчуулга: Энэхүү тайлан нь Англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.*



## **УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ**

2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

**УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ**  
2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

**АГУУЛГА**

	Хуудасны дугаар
Компанийн танилцуулга	3
Онцлох үйл явдлууд	3
Стратеги, хэтийн төлөв	6
Хайгуул болон хөгжүүлэлтийн төслүүд	8
Баруун өмнөд Монголд орших Эрдэнэ Ресурсийн Хөндий Алтны Дүүрэг	8
Хөндий Алтны Төсөл	8
Дүүргийн хэмжээний хайгуул	16
Шинэ хөрөнгө оруулалт	18
Санхүүгийн тайлангийн онцлох мэдээлэл	18
Үйл ажиллагааны хэлэлцүүлэг	19
Дөрөвдүгээр улирал	20
Улирлын үр дүнгийн хураангуй	21
Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц	21
Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл	22
Гэрээгээр хүлээсэн үүрэг	22
Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг	22
Балансаас гадуурх зохицуулалт	23
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол	23
Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт	24
Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл	25
Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт	26
Мэргэшсэн этгээд	26
Бусад мэдээлэл	27

Энэхүү 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Удирдлагын Хэлэлцүүлэг ба Дүн Шинжилгээ (“УХДШ”) нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” эсвэл “Корпораци” гэх)-ийн 2018, 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, аудит хийгдсэн нэгтгэсэн тайлан тодруулгуудын хамт хэрэглэгдэх бөгөөд тус Корпорацийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд хамаарна. Корпорацийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Канад доллараар илэрхийлж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулсан.

Энэхүү хэлэлцүүлэг нь “Урьдчилсан таамаглал” гэж үзэж болохуйц тодорхой мэдээдлүүдийг агуулсан болно. Түүхэн баримтат мэдээдлээс бусад энэхүү тайланд дурдагдах боломжит нөөц, хайгуулын өрөмдлөг, ашиглалтын үйл ажиллагаа, төсөвт санхүүгийн үр дүн, Корпорацийн хүлээж буй үйл явдал, хөгжүүлэлт зэрэг мэдээдлүүд нь алс хэтийг угтуулан харсан мэдээдлүүд болно. Ийнхүү урьдчилсан таамаглал (Корпораци, түүний охин компаниудын тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа, эдийн засаг, зах зээлийн ерөнхий нөхцөл байдал, ашигт малтмалын үнэ, бодит нөөц тогтоолт зэрэгтэй холбоотой төсөөллүүдийг багтаах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй)-д тулгуурласан алсыг харсан мэдээдлүүдэд илэрхийлсэн хүлээлтүүд нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй бөгөөд бодит үр дүн, хөгжүүлэлт нь зах зээлийн үнэ, хайгуул ба үнэлгээний үр дүн, капитал болон санхүүгийн тасралтгүй хүртээмжтэй байдал, эдийн засаг, зах зээл, бизнесийн ерөнхий нөхцөл байдал гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан тэдгээр алс хэтийн төсөөллөөс материаллаг байдлаар ялгаатай байж болно.

Дээр тодорхойлсон эрсдэлийн хүчин зүйлс нь Корпорацид нөлөөлөхүйц бүхий л хүчин зүйлсийг хараахан бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй. Нэмэлт хүчин зүйлсийг Корпорацийн [www.sedar.com](http://www.sedar.com)-д тавигдсан 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Корпорацийн жилийн мэдээ, тайлангийн “Эрсдэлийн хүчин зүйлс” (“Risk Factors”) хэсэгт тэмдэглэсэн болно.

Канад Улсын үнэт цаасны хуулиар тодорхойлогдох энэхүү УХДШ-д тусгасан санхүүгийн аливаа хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг Корпорацийн удирдлага тус УХДШ гарах өдрөөр баталсан болно. Ирээдүйтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хүлээж буй болон төлөвлөж буй ажлын талаар мэдээлэх зорилгоор санхүүгийн хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг өгч байгаа юм. Ийм хэтийн төлөв, ирээдүйн мэдээллүүдийг энэхүү УХДШ-д тусгаснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

## Компанийн танилцуулга

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд хэсэгт хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын тусгай зөвшөөрлүүд дээр хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонтогийн хөрөнгийн бирж (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржид (MSE:ERDN) давхар бүртгэлтэй.

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Энэхүү Төв Азийн Орогены бүс нь БНХАУ-ын нутагт хил дагуу болон бүсийн баруун чиглэлд эпитеpmаль алт болон порфирийн зэс-алтны ордууд сайн судлагдсан байдаг боловч Монгол улсын хувьд 1990-ээд оны дунд үеэс ардчилсан нийгэмд шилжин, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хайгуул хийх боломжийг олгосноор судлагдаж эхэлсэн. Ийнхүү судлагдсанаар дэлхийн хэмжээний алт-зэсийн орд болох Оюу Толгойг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий ("Баян Хөндий" эсвэл "БХ"), Алтан Нар ("Алтан Нар" эсвэл "АН") ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Мөн Баян Хөндий алтны төслөөс зүүн зүгт 40 км зайд Компани Зуун Мод хэмээх томоохон зэс-молибденийн төслийг нээн илрүүлсэн ба энэхүү төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг 100% эзэмшдэг.

Компани 2019 оны 10 сарын 21-нд Tetra Tech Inc-ийн боловсруулсан NI 43-101 урьдчилсан ТЭЗҮ-ийн Техникийн Тайлангийн эерэг үр дүнг танилцуулсан бөгөөд энэхүү тайланд Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын шинэчилсэн АШЭЗТ багтсан. Sustainability East Asia-аар ахлуулан, Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг ("ESIA") 2020 оны эхний хагаст боловсруулж дуусна. Компани нь эцсийн ТЭЗҮ ("BFS"), анхны инженерчлэл загвар ("FEED")-ын ажлуудыг 2019 оны 12 сараас боловсруулж эхэлсэн. 2021 оноос Компани нь алтны олборлолтыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа нь бүс нутгийн томоохон алт олборлогч болох эхний алхам юм.

Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтээс гадна Хөндий Алтны Дүүргийн хайгуулын ажлуудыг үргэлжлүүлэн хийсээр байна. Энэхүү дүүрэг нь суурь болон үнэт металлын систем, зэс-алтны порфирын төрлийн, дундлаг сульфидтай/ карбонат суурь металлын алтны ордууд болон бага сульфидтай эпитеpmаль алт болон алт-мөнгөний системүүдийг багтаадаг. Хэдийгээр хайгуулын эхний шатанд явж буй боловч ирээдүйд нээлт хийх боломжтой үр дүнгүүд гарч байна.

## Онцлох үйл явдлууд

### Хөндий Алтны Төсөл– 100% Эрдэнэ Ресурсийн эзэмшил

- Tetra Tech Inc-ийн боловсруулсан NI 43-101 Техникийн Тайлангийн эерэг үр дүнг танилцуулсан бөгөөд энэхүү тайланд Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын шинэчилсэн АШЭЗТ багтсан (өөрөөр тодотгоогүй тохиолдолд нэг унц алтны үнийг \$1,300 ам.доллар байхаар тооцсон):
  - Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) ("NPV5%") \$97 сая ам.доллар болон дотоод өгөөжийн түвшин ("IRR") 42% хэмээн тооцоологдов.
  - Одоогийн алтны үнэд (нэг унц алтны үнийг \$1,600 ам.доллар) тулгуурлан тооцоолбол татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) ("NPV5%") \$166 сая ам.доллар болон дотоод өгөөжийн түвшин ("IRR") 66% хэмээн тооцоологдоно.
  - Алтан Нарын шинэчилсэн АШЭЗТ-д татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) ("NPV5%") болон дотоод өгөөжийн түвшин ("IRR") нь тус бүр \$24 сая ам.доллар болон 92%-аар тайлагнасан бөгөөд Баян Хөндий төслийн дэд бүтцийг ашиглан, үйлдвэрлэлийн хоёрдугаар үе шат болгон хөгжүүлэхээр тусгасан.
  - Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д танилцуулснаар ашиглалтын хугацаанд татвар болон элэгдлийн өмнөх ашиг нийтдээ \$211 сая ам.доллар байна.
  - Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 520,700 унц баттай болон бодит геологийн нөөц ("Measured and Indicated Resources") тодорхойлогдсон нь 2018 оны 9 сард

тайлагнасан нөөцийн тайлангаас 20% өссөн үзүүлэлт юм. Нэмэлт боломжтой нөөцөд 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц тодорхойлогдсон.

- Баян Хөндийд 3.7 г/т дундаж алтны агуулга бүхий 422,000 унц батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserves”)-ийг тооцоолов.
- Уурхайн ашиглалтын хугацааны хүдрийн дундаж агуулга нь Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д 3.73 г/т, Алтан Нарын АШЭЗТ-д 3.46 г/т байхаар тодорхойлогдсон.
- Уурхайн ашиглалтын хугацаа 11 жил, үүнд: уурхайн барилгын 1 жил, Баян Хөндий ордын ашиглалтын хугацаа 6 жил, Алтан Нар ордын ашиглалтын хугацаа 3 жил байхаас гадна уурхайн хаалтын хугацааг 1 жил байхаар төлөвлөсөн.
- Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д тодорхойлсноор жилд олборлох алтны дундаж хэмжээ 61,000 унц бол Алтан нарын АШЭЗТ-д тодорхойлсноор жилд олборлох алтны дундаж хэмжээ 45,300 унц, мөнгөний дундаж хэмжээ 205,000 унц байна.
- Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг (“AISC”) нь \$746 ам.доллар, Алтан нарын шинэчилсэн АШЭЗТ-д нэг унц алттай дүйцэх нэгж (“AuEq”)<sup>1</sup> нийт нэгжийн өртөг нь \$931 ам.доллар байхаар тусгасан.
- Баян Хөндийн анхны хөрөнгө оруулалт 40 сая ам.доллар болон Алтан Нарын нэмэлт хөрөнгө оруулалт 2 сая ам.доллар байхаар тооцоолсон.
- Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д тодорхойлогдсон эргэн төлөгдөх хугацаа: 2 жил
- Монгол улсад оруулах өгөөж өндөр, уурхайн ашиглалтын хугацаанд Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар (ААНОАТ), Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр (АМНАТ) ба бусад татвар, хураамжид 82 сая ам.доллар төлж, Баянхонгор аймагт 300 гаруй шинэ ажлын байр бий болгоно.
- Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ (“BFS”), анхны инженерчлэл загвар (“FEED”)-ын ажлуудыг эхлүүлсэн.
  - Судалгаануудыг Монголд үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай болон төслийн тоног төхөөрөмж, санхүүжилтэд хамтран ажиллах боломжтой Азид төвтэй байгууллагуудын нэгдэл хамтран боловсруулж байна.
- 2019 оны 8 сарын 5-нд Баян Хөндий, 2020 оны 3 сарын 5-нд Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг тус тус авсан.
  - Ашиглалтын тусгай зөвшөөрлүүд нь 30 жилийн хугацаатай бөгөөд ирээдүйд 70 жил хүртэл сунгах боломжтой тул Хөндий Алтны Дүүргийг урт хугацаанд судлах ба ашиглах боломжийг бүрдүүлж байна.
- Баян Хөндийн усны нөөцийг тооцоолж, гидрогеологийн өрөмдлөгийг гүйцэтгэсэн:
  - Монголын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам нь Баян Хөндий Алтны Төслийн дэд бүтэц, баяжуулах үйлдвэрийн технологийн усны нөөц болон ундаргын түвшинг баталж, бүртгэсэн.
- 2019 оны 4-р улиралд Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-ийн геотехникийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн:
  - Судалгааны үр дүн нь эцсийн ТЭЗҮ-д багтах ба урьдчилсан ТЭЗҮ-д геотехникийн мэдээлэл уламжлалт налуугаар тооцогдсон. Энэ үр дүн нь ил уурхайн ханын налуугийн тогтвортой байдлыг тодорхойлно.
- Баян Хөндийн хүдрийн металлургийн нэмэлт судалгаа хийж гүйцэтгэсэн:
  - Blue Coast Research хүдрийн уусгалтын судалгаа, ус шавхалтын судалгаа, бутлагдах чанарын судалгааг гүйцэтгэн, эцсийн ТЭЗҮ-д багтах боловсруулах үйлдвэрийн загварчлалыг тодорхойлно.
- Sustainability East Asia-аар ахлуулан, Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг (“ESIA”) боловсруулан дуусаж, Монгол Улсын Засгийн газарт Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (“DEIA”) боловсруулж байгаа нь 2020 оны эхний хагаст олон нийтийн хэлэлцүүлгийг хийснээр дуусна.
  - Судалгаагаар орон нутгийн иргэд, төслийн ажилтнуудын амьдрах нөхцөл байдал, бүс нутгийн цаг агаар, агаарын чанар, усны нөөц, замын хөдөлгөөн болон эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судалж, үнэлсэн.



- ТУЗ болон зээлдүүлэгчийн баталснаар Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг 2020 оны эхний хагаст танилцуулна.
- Барилга байгууламжтай холбоотой зарим голлох тусгай зөвшөөрөл, зохицуулалтын зөвшөөрлийг авав.
  - Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (“АМГТГ”) нь Баян Хөндийн Техник Эдийн Засгийн Үнэлгээг (“Mongolian Feasibility Study”) болзолтойгоор баталсан.
  - Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Хөндий Алтны Төслийн боловсруулах үйлдвэр, дэд бүтцэд ашиглахаар төлөвлөсөн усны нөөц, ундаргын хэмжээг баталсан.
  - Баян Хөндий ил уурхай болон холбогдох гадаргуун дэд бүтцэд шаардлагатай 100 га талбайн газар ашиглах зөвшөөрлийг газар зохион байгуулалтын төлөвөгөөний дагуу орон нутаг баталсан.

### Хайгуул

- 2019 онд Баян Хөндий, Алтан Нар төслийн талбайд 4,367 метрийн 22 өрмийн цооног өрөмдөн, Алтан Нар төслийн талбайд өнөөг хүртэл танилцуулсан хамгийн өндөр үр дүн бүхий хайгуулын хөтөлбөрийг хийж гүйцэтгэлээ:
  - Баян Хөндий – Мидфийлд бүс: Урьдчилсан ТЭЗҮ-ийн нөөцийг батлах өрөмдлөгөөр 45 г/т алтны агуулгатай 8 метрийн интервал агуулсан 5.9 г/т алтны агуулга бүхий 112 метрийн интервал огтлогдсон. Түүнд 81 г/т, 95 г/т болон 129 г/т алтны агуулгатай сорьцууд тогтоогдсон (BKD-261)
  - Баян Хөндий - Страйкер болон Мидфийлд бүс: Нарийвчилсан өрөмдлөгөөр BKD-269 цооногт 2.4 г/т алтны агуулга бүхий 32 метр интервал, BKD-270 цооногт 1.7 г/т алтны агуулга бүхий 37 метр интервалууд тус тус огтолж, Баян Хөндий ордод эрдэсжилт үргэлжилж байгааг тодорхойлов.
  - Өмнөд Баян Хөндийн үргэлжлэл: Баян Хөндий ордос өмнө зүгт 350 метрт өрөмдлөг хийсэн бөгөөд 2.4 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал (BKD-268) огтолсон нь Баян Хөндийн алтны ордтой ижил төрлийн галт уулын нэгдлийн хувирал бүхий алтны эрдэсжилт агуулж байв.
  - Алтан Нар – Нээлтийн бүс: Gap Zone (“Урьд нь өрөмдлөг хийж байгаагүй талбай”) дахь өрөмдлөгөөр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135).
  - Алтан Нар – Нээлтийн бүс: 12.2 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал огтолсон ба үүний 2 метр нь 52.9 г/т алтны агуулгатай байсан (TND-134) нь “Gap Zone” -ийн өмнө бүсэд өндөр агуулга бүхий эрдэсжилт байгааг баталж, 4.68 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал (TND-138) огтолсноор Нээлтийн бүсийг өмнө зүгт 10 метр тэлэв.
  - Хар Морь алтны нээлт: Баян Хөндий ордос хойд зүгт 5 км-т Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд илрүүлсэн бүс бөгөөд гадаргаас 87.8 г/т алтны агуулга бүхий чулуулгийн дээж илэрсэн.

### Компанийн тухай

- 2019 онд хөрвөх нөхцөлтэй зээл болон үнэт цаасны санхүүжилтээр \$11.9 сая кан.долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, Баян Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ, эцсийн ТЭЗҮ, Сэндсторм БЦАТ эргүүлэн худалдан авалт, хайгуулын хөтөлбөр болон эргэлтийн хөрөнгөд зарцуулсан.
  - 2019 оны 11 сард Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“EBRD”)-ны оролцоотой \$5 сая ам.доллар (\$6.6 сая кан.доллар)-ын санхүүжилтийг эцэслэв.
  - Үнэт цаасны хаалттай хөрөнгө оруулалтын хүрээнд нийт \$5.3 сая кан.долларыг татан төвлөрүүлсэн.
  - Өнөөгийн \$3.8 сая кан.долларын эргэлтийн хөрөнгө нь Компанийг эцсийн ТЭЗҮ боловсруулж дуусах хүртэл санхүүжүүлэхэд хүрэлцэнэ.

<sup>1</sup> AuEq буюу алттай дүйцэх нэгж нь АШЭЗТ-д алт, мөнгөний хувьд борлуулах боломжтойг харгалзан, тооцсон бөгөөд алтыг нэг унц US\$1,300, мөнгийг нэг унц US\$17.50, өнөөгийн боловсруулах үйлдвэрийн загвард металл авалтыг тусгаагүй тул хар тугалга, цайрын хувьд үнэ цэн заагаагүй болно.

- 2019.04.12-нд Сэндсторм Гоулд Лимитед (“Sandstorm Gold Limited”) компаниас борлуулалтын цэвэр ашгийн төлбөр (“БЦАТ” буюу “NSR royalty”)-ийн 50%-ийг эргүүлэн худалдан авсан:
  - Энэхүү борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн бодит үнэ цэн нь эргүүлэн худалдан авсан \$1.2 сая кан.доллараас илүү гэж үзэв.
- 2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцэст Компанийн алдагдал \$2,683,292 байсан нь 2018 оны 12 сарын 31-ны \$3,656,990 кан.долларын алдагдалтай харьцуулахад буурсан үзүүлэлт юм:
  - 2019 онд капиталжуулсан зардлыг оролцуулсан хайгуулын зардал \$6,694,914 байсан нь 2018 оны \$5,958,692-тэй харьцуулахад өссөн нь Хөндий Алтны төслийн АШЭЗТ, Баян Хөндий урьдчилсан ТЭЗҮ ба Алтан Нар төслийн шинэчилсэн АШЭЗТ-той холбоотой техникийн зөвлөхийн зардал нэмэгдсэнээс шалтгаалсан.
  - Компанийн захиргаа, удирдлагын зардал (мөнгөн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөр болон элэгдлийг оролцуулахгүй) нь 2019 онд \$1,142,956 байсан нь 2018 оны \$1,407,536-тэй харьцуулахад буурсан нь боловсон хүчний өөрчлөлт болон маркетингийн зардал буурсантай холбоотой байв.

## Стратеги, хэтийн төлөв

Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу ахиулах болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий үнэт болон суурь металлын нөөцийг тэлэх зэрэг хоёр стратегийн зорилтын дагуу ажилладаг.

2019 оны 2 сард Эрдэнэ Ресурс нь Алтан Нар, Баян Хөндий ордуудыг нэгтгэн, Хөндий Алтны Төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг (“АШЭЗТ”) бүртгүүлсэн бөгөөд энэхүү тооцооллоор эдийн засгийн хувьд үр ашигтай хэмээн дүгнэгдсэн. RPMGlobal-ын боловсруулсан энэхүү хараат бус тооцооллоор Хөндий Алтны Дүүргийн хөгжүүлэлтэд чухал ач холбогдол болохуйц анхан шатны хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал бага, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа богино төслийг хөгжүүлэх боломжтой үр дүнгүүд гарсан. Хөндий Алтны Төслийн олборлолтыг өндөр агуулга бүхий ил аргаар олборлох боломжтой Баян Хөндийн Страйкер бүсээс эхлэн, цаашид Баян Хөндийн зэргэлдээ орших бүсүүд, түүнчлэн Алтан Нар ордод олборлолт хийхээр төлөвлөсөн.

Эрдэнэ Ресурс нь NI 43-101 стандартын дагуу Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын АШЭЗТ-ыг Тетра Тек (“Tetra Tech”)-ээр удирдуулан боловсруулж, 2019 оны 10 сарын 21-нд эцэслэсэн. Баян Хөндийн шинэчилсэн геологийн нөөцийн тооцоолол, Баян Хөндийн үйлдвэрийн нөөцийн тооцоолол, хараат бус байгууллагуудаас үнийн санал авах зэрэг үйл ажиллагаа багтсан бөгөөд Баян Хөндий Алтны Төсөл нь бага зардал, өндөр өгөөж бүхий төсөл гэдгийг Тетра Тек баталсан.

2019 оны 12 сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны төслийн эцсийн ТЭЗҮ (“BFS”), анхан шатны инженерийн загварчлал (“FEED”) боловсруулах ажлуудыг эхлүүлсэн бөгөөд эдгээр төслүүдийг боловсруулснаар тусгай зөвшөөрлүүд, төслийн санхүүжилт болон бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх ТУЗ-ийн шийдвэр гаргуулах нөхцөл үүснэ. Энэхүү судалгаануудыг олон улсын болон Монголын хамтарсан зөвлөх байгууллагууд хийж, уурхайн загварчлал, боловсруулах үйлдвэрийн анхан шатны инженерийн загварчлал, холбогдох дэд бүтэц болон гидрогеологийн судалгаа, нарийвчилсан хаягдлын удирдлагын төлөвлөгөө болон шинэчилсэн эдийн засгийн загварчлалыг боловсруулна. Компани нь 2020 оны дундуур ТЭЗҮ-ийг танилцуулахаар төлөвлөж байна. Дээрх судалгааг Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай Канад, Австрали-Азийн мэргэжлийн зөвлөх байгууллагууд хамтран боловсруулна:

- Roma Group Ltd (“Roma”) нь инженерчлэл, бизнес болон хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн тооцоолол болон компанийн үнэлгээ, компаниудын нэгдэл зэрэг үйл ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг бус нутгийн тэргүүлэх байгууллага юм. Рома нь NI 43-101 стандартын дагуу эцсийн ТЭЗҮ-ийг боловсруулах бөгөөд гидрологи - гидрогеологи, геотехникийн судалгаа, зардлын тооцоолол, санхүүгийн загварчлалыг хийж гүйцэтгэнэ. Рома нь Хонг Конгийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компани бөгөөд Монгол болон олон улсад уул уурхай, санхүүгийн байгууллагуудтай хамтран техникийн судалгаа, үнэлгээний төслүүд дээр ажилласан туршлагатай.
- Эцсийн ТЭЗҮ, анхан шатны инженерийн загварчлалын тайланг боловсруулахад дараах дотоодын компаниуд хамтран ажиллаж байна. Үүнд: геотехник инженерчлэлийн Соил Трейд ХХК

("Soil Trade"), инженерчлэл болон барилга байгууламжийн Лобо Эрдэнэ ХХК ("LOBO"), уурхайн инженерчлэлийн зөвлөх байгууллага Прожект Майнинг ХХК ("Project Mining"), байгаль орчны зөвлөх байгууллага Эко Трейд ХХК ("Eco Trade") нар багтана. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын хууль, дүрэм журмуудад нийцүүлэн үйл ажиллагааны бүхий л үе шатанд дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг чухалчилсаар ирсэн.

- O2 Mining Ltd ("O2") нь уурхайн төлөвлөлт ба загварчлал (уурхайн хаалт багтсан) дээр хамтран ажиллах бөгөөд Монголын барилгын тусгай зөвшөөрлүүд, үйлдвэрлэлийн бус дэд бүтцийн төлөвлөлтийг багтаах анхан шатны инженерийн загварчлал ("FEED")-ыг хамтран боловсруулна. O2 нь Хонг Конг-д төвтэй, Австрали, Азийн орнуудын уурхай хөгжүүлэлтийн чиглэлээр мэргэшсэн компани бөгөөд Монгол улсад алт болон нүүрс олборлодог гурван уурхайн ашиглалт, үйл ажиллагааг удирдсан туршлагатай компани юм.
- Auralia Mining Consulting ("Auralia") нь эрдсийн нөөцийн эцсийн загварчлал болон уурхайн загварын оновчлолыг эцэслэнэ. Ауралиа нь Австрали улсын Перт хотод төвтэй уурхайн инженерчлэл, нөөцийн тооцоолол зэргээр мэргэшсэн зөвлөх байгууллага бөгөөд Баррик ("Barrick"), Гоулд Роуд Ресурсиз ("Gold Road Resources") зэрэг алтны компаниудтай хамтран ажиллаж байсан туршлагатай компани юм.
- 360-Global Inc ("360-Global") нь эцсийн ТЭЗҮ, анхан шатны инженерийн загварчлалд багтах баяжуулах үйлдвэрийн загварчлал, инженерчлэлийн судалгааг хийж гүйцэтгэнэ. 360-Глобал Инк нь Австрали, Филиппин улсуудад төвтэй бөгөөд Монгол болон олон улсад алтны боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн загварчлал хийх үйлчилгээ үзүүлдэг туршлагатай байгууллага юм.
- ATC Williams PTY Ltd ("ATCW") нь эрдсийн хаягдлын байгууламж, удирдлага болон уурхайн хаалтын төлөвлөлтийг боловсруулж ажиллана. ATCW нь Австралийн Мелбурн хотод төвтэй бөгөөд Монголд Оюу Толгой зэрэг төслүүдэд хаягдлын тээвэр, хадгалалт, хаалт болон усны удирдлагын үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.
- Blue Coast Research Ltd ("BCR") нь Хөндий Алтны Төслийн металлургийн судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. BCR нь алтны ордуудын судалгаанд мэргэшсэн бөгөөд өнөөг хүртэл Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн металлургийн судалгааг хийж гүйцэтгэж байгаа билээ.

Дээрх судалгаануудыг боловсруулж эхэлснээс хойш Баян Хөндийн боловсруулах үйлдвэрийн төлөвлөж буй байршлаас 3.2 км зайд таван боловсруулах-усны цооногийг гаргасан. Усны нөөц нь ашиглалтын хугацаанд Баян Хөндийн байгууламжийн шаардлагад хангалттай нийцнэ гэж үзэн, Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам бүртгэн, баталсан. Түүнчлэн, төлөвлөсөн хээрийн кэмпээс 200 метрт усны худаг гарган, бүртгүүлсэн.

Баян Хөндийн ил уурхайн төлөвлөлтийн хүрээнд төрөл бүрийн литологийн бат бэх, тогтвортой байдлын үнэлгээг гаргах зорилгоор 2019 оны 4-р улиралд зургаан геотехникийн цооног (745 метр) өрөмдсөн. Эдгээр мэдээллийг уурхайн төлөвлөлтийн үед ил уурхайн ханын налуугийн тогтвортой байдлыг тодорхойлоход ашиглана. Урьдчилсан ТЭЗҮ боловсруулах үед мэдээлэл хангалтгүй байсны улмаас уламжлалт налуугийн таамаглалд тулгуурласан.

2019 оны сүүлийн хагаст Баян Хөндийн төлөвлөсөн ил уурхайгаас цуврал төлөөлөл бүхий найрлага, өрмийн цөмийг металлургийн туршилтад оруулахаар Канадын Бритиш Колумб руу хүргүүлсэн. Металлургийн туршилтын үр дүн нь инженерүүдийг бохирдлын (нунтаглах) оновчлол; алт авалтын хувьд оновчтой нунтаглах хэмжээг тодорхойлох; ус ашиглалтыг багасгахын тулд хамгийн үр дүнтэй ус шавхах үйл явцыг тодорхойлох; алт авалтын хүрээнд нүүрсэнд уусгах чанарыг тодорхойлох; боловсруулах үйлдвэрийн лагийн хатуулгийн хувийг тодорхойлох; хаягдал дахь цианидын хэмжээг бууруулах хоргүйжүүлэлтийн туршилтуудыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл болно. Эдгээр туршилтуудын дийлэнх хэсгийг хийж гүйцэтгэсэн бөгөөд эцсийн ТЭЗҮ-д багтах Баян Хөндийн төлөвлөж буй боловсруулах үйлдвэрийн загварчлалыг оновчтой болгоход инженерүүд ашиглана.

Үүнтэй зэрэгцэн, төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ ("ESIA")-г Sustainability East Asia компани боловсруулж байгаа бөгөөд орон нутаг болон төслийн ажилтнуудад үзүүлэх сөрөг нөлөө багатай гэдэг дүгнэлтэд хүрсэн. Төслийн цар хүрээ бага, салбартаа тэргүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авдаг, төслийн эдийн засгийн үр өгөөж нь байгаль орчны бага, дунд зэргийн нөлөөллөөс харьцангуй өндөр байх хүлээлттэй байна. Баян Хөндий төслийн Монголын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ ("DEIA") нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ ("ESIA")-д тулгуурласан бөгөөд 2020 оны эхний хагаст олон нийтийн хэлэлцүүлгийг хийснээр эцэслэгдэнэ.


2019 оны 8-р сарын 5-нд Ашигт малтмал, газрын тосны газар ("АМГТГ") Баян Хөндий Төслийн талбайд MV-021444 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон. Хөндий ашиглалтын

тусгай зөвшөөрлийн талбай нь 2,309 га бөгөөд үүнд Баян Хөндий нөөц, Хар Морь, Алтан Сум, Хойд Хөндий, Төв структурын бүс болон Өмнөд Хөндий зэрэг хэтийн төлөв бүхий талбай багтаж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай олгогдох бөгөөд компани үргэлжлүүлэн 70 жил хүртэл сунгах боломжтой. Энэхүү өргөдлийн хүрээнд 2,205 га талбай нь хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөлд хамаарахгүй болно. 2019 оны 11 сарын 1-нд АМТГТ нь Эрдэнэ Ресурсийн Алтан Нар төслийн нөөцийг бүртгэж авсан бөгөөд Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 3 сарын 5-нд баталгаажуулсан.

Эрдэнэ Ресурс нь Хөндий, Алтан Нар тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд шинэ илрэлийг нээн илрүүлэх, хайгуулын боломжийг судалж байна. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, 20 гаруй хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон. Мөн 2018 оны сүүлээр Монгол Улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож эхэлсэн боловч Компанийн сонирхож буй талбайнууд сонгон шалгаруулалтын багцад ороогүй байна. Ирээдүйд Компанийн сонирхол бүхий талбай сонгон шалгаруулалтад орсон тохиолдолд компани идэвхтэй өрсөлдөх төлөвлөгөөтэй байна.

## Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд

### Монгол улсын баруун өмнөд бүсэд орших Эрдэнэ Ресурсийн Хөндий Алтны Дүүрэг



2018 оны 9 сарын 15-нд Компани нь Хөндий алтны төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг танилцуулсан. 2019 оны 10 сарын 21-нд Тетра Тек нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д шинэчилсэн геологийн нөөцийн тооцоолол, Баян Хөндийн үйлдвэрийн нөөцийн тооцооллыг боловсруулсан. Зуун Модын ордоос бусад Компанийн эзэмшлийн хайгуулын талбай нь хайгуулын эхний шатанд явж буй бөгөөд NI 43-101 тайлагналын стандартын дагуу тайлагнах нөөцийн тайланг боловсруулаагүй. Дээр дурдсан ордуудаас гадна энэхүү Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээнд дурдсан талбайн боломжит агуулга болон хэмжээ нь урьдчилан таамагласан таамаглал бөгөөд нөөцийн тайланг боловсруулах хэмжээний хайгуулын судалгаа хийгдээгүй болно. Компанийн төслүүдийн тухай нэмэлт мэдээллийг [www.sedar.com](http://www.sedar.com), SEDAR дахь компанийн хуудсаас NI 43-101 техникийн тайлан, жилийн эцсийн мэдээллийн эмхтгэлүүдээс ("AIF") авч танилцах боломжтой.

## Хөндий Алтны Төсөл

Хөндий Алтны Төсөл нь Компанийн газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий Баян Хөндий, Алтан Нар ордуудаас бүрддэг. Компанийн 100% эзэмшил бүхий Баян Хөндий ("Rich Valley") алтны орд нь

Монгол улсын баруун өмнө зүгт, Баян Хөндийн нөөцийг агуулсан 2,309 га Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг хамардаг. Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Тетра Тек (“Tetra Tech”) боловсруулж, “Хөндий Алтны Төсөл NI 43-101 эрдсийн нөөцийн техникийн тайлан” (“Khundii Gold Project ni 43-101 Technical Report”) нэртэйгээр бүртгүүлсэн Баян Хөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Эрдэнэ Ресурсийн Хар Морь (“Dark Horse”), Алтан Сум (“Altan Arrow”), Хойд Хөндий (“Khundii North”) болон Баруун Хөндий (“Khundii West”) хэтийн төлөв бүхий талбайнууд багтаж байна.

Компанийн 100% эзэмшил бүхий Баян Хөндий алтны ордыг 2015 оны 2 дугаар улиралд нээж илрүүлэн 2015 оны 4-р улиралд анхны өрөмдлөгийг хийж, эхний цооногоос 14 метрийн гүнд 27.5 г/т алтны агуулгатай 7 метр зузаантай интервал илрүүлсэн. 2017 онд хийсэн хэмжээст өрөмдлөгөөр Страйкер бүсээс зүүн хойш 200м зайтай орших Мидфийлд бүсэд тохиолдсон эрдэсжилт нь залуувтар хучдасын доогуур багадаа 280м цааш сунан тогтсон байв. Одоогоор Баян Хөндийн Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүдээс 42 метрийн гүнд 80 метр 6.0 г/т алтны илэрц бүхий ВКД-98, 1 метр 2,200 г/т алтны илэрц бүхий 14 метр 158 г/т алтны агуулгатай ВКД-231 гэх мэт хамгийн өндөр агуулга бүхий эрдэсжсэн интервалууд илрээд байна. Өрөмдлөгийн хөтөлбөрөөр гурван бүсэд маш өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт үргэлжилж байгааг тогтоосон: Страйкер бүсэд эрдэсжилт газрын гадаргаас эхлэн, Мидфийлд, хойд Мифийлд бүсүүдэд өндөр агуулга бүхий бүс нь газрын дөт гүнээс эхлэн тогтвортой үргэлжилж байгааг тодорхойлсон. 112 метрийн интервалтай 5.9 г/т алт огтолсноос харахад энэ гурван талбайн өндөр агуулга бүхий бүс нь өргөн байх боломжтой.

Баян Хөндий нь алтны өндөр агуулгатай, гадаргад ойр, хялбар металлургийн нөхцөлтэй тул Корпорацийн голлон төвлөрөх төсөл болоод байна. Компани нь Баян хөндийд нийтдээ 45,377 тууш метр бүхий 270 алмазан цооног өрөмдөөд байгаа юм.

2019 оны 9 сард Компани нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1,114 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хийж гүйцэтгэсэн. Өрөмдлөгөөр Хойд Хөндий, Өмнөд Хөндий ба Төв Структурын Бүсэд гурван хайгуулын өрөмдлөг, нарийвчилсан өрөмдлөг болон металлургийн дээжлэлтийн өрөмдлөгүүд хийсэн. Өрөмдлөгөөр Баян Хөндий ордоос өмнө зүгт 350 метрт Өмнөд Хөндий бүсэд 2.45 г/т алтны агуулга бүхий интервал огтолж, Хойд Хөндий ба Төв Структурын Бүсийн алтны эрдэсжилт үргэлжилж байгааг тодорхойлсон. Страйкер, Мидфийлдийн урьд нь хязгаарлагдмал өрөмдлөг хийж байсан бүсэд хоёр цооног өрөмдсөн нь энэ бүсийн нөөцийн мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой. Энэхүү хоёр цооногоор өндөр агуулга огтолсон нь ВКД-269 цооногоор 6.6 г/т алтны агуулга бүхий 6.3 метрийг багтаасан 2.4 г/т алтны дундаж агуулга бүхий 32 метрийн интервал огтолсон, ВКД-270 цооногоор 4.7 г/т алтны агуулга бүхий 7 метрийг багтаасан 1.7 г/т алтны дундаж агуулга бүхий 37 метрийн интервал огтолсон.

2019 оны 4-р улиралд Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь судлагдаагүй бүсэд гадаргын хайгуулаар Хар Морь бүсийг нээсэн. Хар Морь нь Баян Хөндий ордоос хойд зүгт 4.5 км-т, Алтан Сум-аас зүүн өмнө зүгт 32.9 г/т алтны агуулга бүхий чулуулгийн дээж авснаар шинээр нээн илрүүлсэн. 2019 оны 4-р улиралд нэмэлт гадаргуун хайгуул буюу геологийн зураглал, геохимийн судалгааг (чулуун болон хөрсний дээжлэлт) хийснээс бш чулуун дээжинд буюу сиенитийн порфирийг зүссэн комб кварц-адуларын судалд 5 г/т-оос 87.8 г/т хүртэлх алтны агуулга илэрсэн. 2019 оны 4-р улиралд гүйцэтгэсэн хайгуулын ажил нь Хар Морь талбайг баруун зүгт 1.5км х 2км болгон тэлснээр зэргэлдээ орших Алтан Сум алтны хэтийн төлөвт талбайтай залгаа болов.

Мөн, Страйкер бүсийн төвд өндөр агуулга бүхий хүдрийн металлургийн судалгаа хийх зорилгоор өргөн диаметрийн PQ цооног өрөмдсөн. Металлургийн судалгаа нь эцсийн ТЭЗҮ-д багтах боловсруулах, нунтаглах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллүүдийг гаргана.

Компанийн 100% эзэмшлийн Алтан Нар (“Golden Sun”) орд нь Баян Хөндий ордоос баруун хойд зүгт 16 км-т орших Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн 4,669 га талбайд оршдог. Компани ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 3-р сарын 5 өдөр АМГТГ-аас авсан бөгөөд нийт 30 жилийн хугацаатай дээр нэмж 20 жилээр хоёр удаа сунгах нөхцөлтэй юм. Тусгай зөвшөөрлийн талбай нь 5.6 х 1.5 км хүдэржилттэй корридор эрдэсжсэн 18 ширхэг (алт, мөнгө, хар тугалга, цайр) хэтийн төлөвт хайгуулын талбайг агуулдаг. Анхны хоёр нээлт болох “Нээлтийн бүс” (“НБ”) болон “Хойд Холбоос” (“ХХ”) бүсүүд нь Эрдэнэ Ресурсийн 2018 оны 2-р улиралд гаргасан нөөцийн шинэчилсэн тайланд мэдээлснээр хамгийн ихээр судлагдсан газрын гадаргууд дөт гүнд өндөр агуулгатай бүсүүдийг агуулдаг.

Алтан Нар орд нь өдгөө ашиглалтын шатанд шилжихээр эцсийн ТЭЗҮ-ийн судалгаа хийгдэж буй Баян Хөндий ордоос хойд зүгт 16км зайтай оршдог, карбонат-полиметаллт алтны (CBMG) орд гэж үзэж байгаа ба нийт 5.6км урттай гадаргын эрдэсжсэн бүс нь гүндээ болон одоогоор мэдэгдэж буй суналын дагуу нөөц тогтоох боломжтой гэж үздэг. Карбонат-полиметаллт алтны орд нь эпиптермаль

ордын дэд бүлэгт хамаардаг ба Баррик Гоулдын Поргера уурхай (Папуа Шинэ Гвиней), Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай (Индонези), Лундинын Фрута Дел Норте (Эквадор), Континентал Гоулдын Буритика төсөл (Колумби) зэрэг ордууд нь энэ төрөлд багтдаг. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын дээд хэсэгт тохиолдох ба эрдэсжилт нь 500 гаруй метр гүн үргэлжлэх боломжтой байдаг.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Компани нь Баян Хөндийн нээлтэд төвлөрөн ажилласан тул Алтан Нар төсөлд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн. Нээлтийн бүсэд 2019 оны 4-р улиралд нийт 667 тууш метр өрөмдлөгийн судалгаа хийсэн. Нээлтийн бүсэд урьд нь өрөмдлөг хийж байгаагүй 70 метр талбайд (“Gar Zone”) өндөр агуулга бүхий цөмийг судлахаар 130 метрийн гүн дөрвөн цооног өрөмдсөн. Ордыг өмнө зүгт тэлэх боломжтой талбайг тав дахь цооноогоор шалгасан.

2019 оны 4-р улирлын хайгуулын хөтөлбөрийн үр дүнгээр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135) нь өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүнд тооцогдож байна. 2019 оны 4-р улирлын үр дүнгүүд нь урьд нь бага агуулга бүхий нөөцийн блокуудын гадна оршиж, Нээлтийн бүсийн өндөр агуулга бүхий цөмийг тэлж, өндөр агуулга бүхий эрдэсжилт тууштай үргэлжилж буйг харууллаа. 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн нь Алтан Нарын нөөцөд эерэгээр нөлөөлж, дүүргийн бусад бүсүүдэд тэлэлт хийх боломжийг нээж байна. Өрөмдлөгийн хөтөлбөр нь Нээлтийн бүсийн өмнө зүгийн дагуу структурын коридорын дагуу аномаль алт, суурь металл тууштай үргэлжилж буйг харууллаа. Ирээдүйн хөтөлбөрүүдээр үргэлжлүүлэн судална.

Өнөөг хүртэл Нээлтийн бүс ба Хойд Холбоо талбайд бодитой нөөц тодорхойлогдсон. Алтан Нарын үлдсэн 16 хэтийн төлөв бүхий талбайд Компани үргэлжлүүлэн хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлж, эрдэсжсэн системийн ойлголтыг бататгахаар төлөвлөсөн.

### Эрдсийн нөөц

Эрдэнэ Ресурс нь 2019 оны 10 сарын 1-нд Хөндий Алтны Төслийн шинэчилсэн нөөцийн тооцооллыг танилцуулсан бөгөөд энэхүү тооцооллыг Тетра Тек (“Tetra Tech”) нь NI 43-101 стандартын дагуу боловсруулсан. Хөндий Алтны Төслийн нөөц нь Баян Хөндий ба Алтан Нар ордын нөөцийн жигнэсэн дундаж агуулга дээр суурилан тооцоологдсон. Тетра Тек-ийн боловсруулсан Баян Хөндий нөөцийн тооцоолол нь 2019 оны 10 сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон. RPMGlobal нь Алтан Нар ордын нөөцийн тооцооллыг хийсэн бөгөөд тооцооллын тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн 2018 оны 5 сарын 10-ны хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

Доорх хүснэгтэд Хөндий Алтны Төслийн захын агуулга, хэмжээ болон агуулгын мэдрэмтгий чанарын судалгааны хураангуйг харуулав<sup>1</sup>:

Захын агуулга <sup>(1,2)</sup>	Баялгийн ангилал	Хэмжээ (Mt)	Агуулга (Au г/т)	Алт (мян.унц)
0.4	Баттай ба Бодит	14.0	<b>1.91</b>	863
	Боломжит	4.8	<b>1.91</b>	295
<b>Санал болгосон<sup>(3)</sup></b>	<b>Баттай ба Бодит</b>	<b>10.1</b>	<b>2.59</b>	<b>839</b>
	<b>Боломжит</b>	<b>4.3</b>	<b>2.10</b>	<b>289</b>
1.0	Баттай ба Бодит	6.5	<b>3.65</b>	762
	Боломжит	3.6	<b>2.38</b>	275
1.4	Баттай ба Бодит	5.2	<b>4.33</b>	727
	Боломжит	3.2	<b>2.56</b>	266

(1) Баян Хөндий, Алтан Нарын нэгтгэсэн нөөц

(2) Захын агуулга нь Баян Хөндийг зөвхөн алтаар, Алтан Нарыг алттай дүйцэх нэгжээр (“AuEq”)² хэмжсэн. Алтан Нарын нөөцийн тооцоололд алттай дүйцэх нэгжийн тооцооллыг алтны үнэ US\$1,310/унц, мөнгөний үнэ US\$18/унц хар тугалга US\$2,400/т, цайр US\$3,100/т тус тусын үнэлгээтэй байхаар төсөөлсөн.

(3) Tetra Tech нь Баян Хөндийн ил уурхайн нөөцийг 0.55 г/т, RPM нь Алтан Нарын ил уурхайн нөөцийг 0.7 г/т харин ил уурхайгаас доош орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т алттай дүйцэх нэгжээр² тооцоолохыг зөвлөсөн.

Геологийн нөөцийг тооцоолохдоо Datamine Studio RMTM-ийн програм хангамжид суурилан энгийн кригинг (“Ordinary Kriging”) аргыг ашиглан геологийн загвар, геостатистик, блок загвар дээр тулгуурлан хийж гүйцэтгэсэн. QA/QC протокол, бэлтгэл, тээвэрлэлт зэргийг Tetra Tech хянаж баталгаажуулсан.

Геологийн нөөцийг төлөвлөж буй ил уурхайн ханаар хязгаарлан, хэд хэдэн захын агуулгад тулгуурлан тооцоолсон боловч 0.55 г/т захын агуулгыг ашигласан. Захын агуулгын тооцооллууд болон төсөөллүүдийг доор танилцуулсан хүснэгт, тэмдэглэлүүдэд дурдсанаар цаашид олборлолтын шатанд тохиромжтой гэж үзсэн.

Захын агуулга <sup>(1)</sup>	Ангилал	Тоо хэмжээ (сая т)	Агуулга ( Au г/т )	Алт (мян.унц)
0.55	Баттай	1.4	3.77	171
	Бодит	3.7	2.93	350
	<b>Баттай ба Бодит</b>	<b>5.1</b>	<b>3.16</b>	<b>521</b>
	Боломжит	0.9	3.68	103

**Тэмдэглэл**

- (1) Геологийн нөөцийн тооцооллын тайланг Камерон Нортонь удирдлага дор боловсруулав, тэрээр Tetra Tech-ийн орон тооны ажилтан бөгөөд мэргэшсэн геосудлаач. Ноён Нортон хэлэлцэж буй холбогдох ордын эрдэсжилт болон ордын хэв маяг, хэлбэрийн талаар хангалттай туршлагатайгаас гадна CIM-ийн ил тод байдлын стандартад тодорхойлсон Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн.
- (2) Дээрх хүснэгтэд тайлагнасан бүх нөөцийн тооцооллууд нь 2019 оны 4-р сарын 22-ны өдөр хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймлосон болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
- (3) Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
- (4) Нөөцийн тайлангийн захын агуулгыг 0.55 г/т байхаар тооцсон. Эдгээр захын агуулгын тооцоог Tetra Tech нь ил уурхайн аргаар боловсруулах төсөөлөлд тулгуурлан, алтыг нэг унц нь US\$1,350, ил уурхайн зардал нэг тонн тутамд US\$6, нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$16, ерөнхий ба захиргааны зардал нэг тонн тутамд US\$5 доллар, металл авалт 0.95% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан.
- (5) Нөөцийн тайлан нь алтны үнэ \$2,000 ам.доллар байхад оновчтой уурхайн ханын хязгаараар тооцоологдсон бөгөөд эдийн засгийн өгөөж нь дээрх тооцооллууд дээр үндэслэсэн.
- (6) Нөөцийн тайланд эрдэсжсэн бүсийн дундаж нягтаршил 2.66 т/м3 байхаар төсөөлсөн.
- (7) Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоог үй болно.
- (8) Баттай ба бодит нөөц нь эдийн засгийн тооцоололд багтахгүй. Боломжит нөөцийг техник эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд хүндрэлтэй. Үйлдвэрлэлийн нөөцөд багтаахгүй.

Шинэчилсэн нөөцийн тайланд агуулга болон хэмжээ нь Баттай болон Бодит нөөцийн нийлбэрээр 20%-аар өссөн үзүүлэлттэй гарсан. Энэхүү өссөн үзүүлэлт нь 2019 оны нарийвчилсан өрөмдлөгөөр өндөр агуулга бүхий эрдэсжилт үргэлжилж байгааг баталгаажуулж, Тетра Тек-ийн геологийн загварчлалаар дахин тодорхойлолт хийсэнтэй холбоотой.

Доорх хүснэгтэд Баян Хөндийн үйлдвэрлэлийн нөөцийг харуулав. Урьдчилсан ТЭЗҮ-д багтсан нөөцийн тооцооллыг Tetra Tech 2014 оны ашигт малтмалын баялаг болон нөөцийн CIM стандартын тодорхойлолтыг ашиглан, NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартад (“NI 43-101”) нийцүүлэн 2019 оны 10-р сарын 1-нд шинэчлэн боловсруулсан. Үйлдвэрлэлийн нөөцөд батлагдсан болон магадалсан (“Proven and Probable”) нөөцөд шилжүүлсэн Баттай болон Бодит (“Measured and Indicated”) геологийн нөөц багтсан болно. Уурхайн блок-д орох хэмжээ, алтны агуулгыг тооцсон ба нөөцийн тооцоололд агуулгын бохирдол болон металл авалтын хорогдуулга хийгдсэн.

	Хэмжээ (сая/т)	Агуулга (г/т Au)	Агуулсан алт (мян.унц)
Батлагдсан нөөц (A')	1.1	4.4	165
Магадалсан нөөц (B')	2.4	3.4	256
<b>Нийт Үйлдвэрлэлийн Нөөц (A') ба (B')</b>	<b>3.5</b>	<b>3.7</b>	<b>422</b>

**Тэмдэглэл**

- (1) Ашигт малтмалын нөөцийн тооцоолол нь 2019 оны 10-р сарын 15-аас хүчин төгөлдөр болсон. Тооцооллыг боловсруулсан Мэргэшсэн мэргэжилтэн нь Tetra Tech компанийн уурхайн менежер, Маурий Файфер (Maurie Phifer) (P.Eng)
- (2) Ашигт малтмалын нөөцийн Тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлург болон Газрын тосны дээд сургууль (CIM) Тодорхойлолтын Стандарт (2014 CIM Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны CIM Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн.
- (3) Нөөцийг ил уурхайн олборлолтын аргаар олборлоно гэж тооцоолсон
- (4) Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
- (5) Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТ-ийг уурхайн бус алдагдал, тэвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон. БЦАТ-ийн захын хязгаарыг \$22.93 гэж тооцоолсон бөгөөд 5%-ийн роялтиг багтаасан дүн юм.
- (6) Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,267 ам.доллар, уурхайн олборлолтын зардал \$2.5 ам.доллар/тонн, боловсруулах зардал \$16.46 ам.доллар/тонн, ерөнхий ба захиргааны зардал \$6.58 ам.доллар/тонн зэрэг төсөөллүүд дээр үндэслэсэн.
- (7) Ашигт Малтмалын Нөөцөд 9% бохирдолт болон 5% алдагдал багтсан.

RPMGlobal нь 2018 оны 5 сард Алтан Нарын эрдсийн нөөцийн тооцооллыг танилцуулахдаа хэд хэдэн захын агуулгыг тооцсон бөгөөд RPMGlobal Баян Хөндийн ил уурхайн нөөцийг 0.7 г/т алттай дүйцэх нэгж<sup>2</sup> (Доорх тэмдэглэлийн 8 дахь зүйлтэй танилцана уу) харин ил уурхайгаас доош гүнд орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор тооцоолохыг зөвлөсөн. Алтан Нар алт-полиметаллын төслийн геологийн нөөцийн хураангуйг доорх хүснэгтэд үзүүлэв. Нөөцийн дэлгэрэнгүй мэдээллийг 2018 оны 5-р сарын 10-ны хэвлэлийн мэдээнээс авна уу.

Захын агуулга AuEq <sup>2</sup> г/т	Баялгийн Ангилал	Тоо хэмжээ (Mt)	Агуулга				Агуулсан Металл					
			Au г/т	Ag г/т	Zn г/т	Pb г/т	AuEq <sup>2</sup> г/т	Au мян. унц	Ag мян. унц	Zn мян.т	Pb мян.т	AuEq <sup>2</sup> мян.унц
0.7	Бодит Боломжит	5.0	2.0	14.8	0.6	0.6	2.8	318	2,350	31.6	29.0	453
		3.4	1.7	7.9	0.7	0.7	2.5	186	866	23.7	22.3	277

Тэмдэглэл:

- (1) Ил уурхайн нөөцийт 0.7 г/т, ил уурхайгаас гүнд буй нөөцийн захын агуулгыг 1.4 г/т AuEq байхаар тооцоолсон.
- (2) Энэхүү нөөцийн тайлан дахь мэдээллүүд нь RPM-ийн ажилтан, Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн Жереми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловсруулагдсан. Ноён Кларк нь дурдсан ордын эрдэсжилтийн талаар өндөр туршлагатай бөгөөд CIM Тодруулгын стандартын дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
- (3) Нөөцийн тайлангийн талаар дээрх хүснэгтэд багтсан мэдээлэл нь 2018 оны 5-р сарын 7 хүртэл хийгдсэн өрмийн судалгааны үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурлан бүхэл тоонд шилжүүлсэн болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
- (4) Тайланд тусгагдсан нөөцийн агуулга нь CIM стандартын дагуу тайлагнагдсан.
- (5) Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан
- (6) Нөөцийн тайланд бохирдол болон хүдрийн алдагдлын хүчин зүйлсийг багтаагаагүй.
- (7) Олборлолт хийгдэх болсон тохиолдолд металл авалтын алдагдал гарах магадлалтай
- (8) AuEq буюу алттай дүйцэх нэгж<sup>2</sup> нь алтыг нэг унц US\$1,310, мөнгийг нэг унц US\$18, хар тугалга нэг тонныг US\$2,400, цайрыг нэг тонныг US\$3,100 байхаар тооцоолсон.

### Эдийн засгийн тооцоолол

2019 оны 10 сарын 21-нд Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун урд бүсэд байрлах өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус техникийн тайланг танилцуулсан. Энэхүү тайланд Баян Хөндий алтны ордын урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нар ордын шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол багтана. Мөн Баян Хөндийн эрдсийн нөөцийн шинэчилсэн тооцоолол багтсан. Тайланг Тетра Тек компани NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу боловсруулсан.

Анхан шатны эдийн засгийн тооцооллоор өндөр агуулга бүхий ил аргаар олборлох боломжтой Баян Хөндийгөөс эхлэн олборлож, цаашид Баян Хөндийн зэргэлдээ орших талбайд олборлолт хийхээр төлөвлөж байна. Хөгжүүлэлтийн төлөвлөгөөнд уламжлалт нүүрсэнд уусгах технологи болон гравитациар баяжуулах аргаар өдөрт дунджаар 1,800 тонн хүдэр боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөгдсөн. Баян Хөндийн ордын олборлолтыг дууссаны дараа Хөндий Алтны Төслийн ашиглалтын хугацааны 8-10 дахь жилд Алтан Нарын нөөцийг ил аргаар олборлоно. Алтан Нарын АШЭЗТ-д багтсан санхүүгийн загварчлалд Баян Хөндийн боловсруулах дэд бүтцийг ашиглахаар тооцоолсон тул Алтан Нарын нөөцийн бие даасан санхүүгийн загварчлал хийгдээгүй.

Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндийн 3.73 г/т алтны дундаж агуулга бүхий 3.5 сая тонн хүдэр багтсан бөгөөд эдгээр нь бүгд батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц ("Proven and Probable Reserves") юм. Алтан Нарын АШЭЗТ-д 3.46 г/т алт ба 17 г/т мөнгөний агуулга бүхий 1.8 сая тонн хүдэр багтсан бөгөөд үүний 66% нь бодитой нөөц ("Indicated Resources") юм.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоололд боломжит нөөц агуулсан. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл ихтэй. Эдийн засгийн үр ашиг багатай геологийн нөөцийг үйлдвэрийн нөөц, эдийн засгийн тооцоололд багтаахгүй.

### Хүснэгт 1. Хөндий Алтны Төслийн онцлох үзүүлэлтүүд

Төсөөлөл		БХ У-ТЭЗҮ	АН АШЭЗТ
Алтны үнэ		US\$/унц	1,300
<b>Олборлолт</b>			
Уурхайн ашиглалтын хугацаанд хүдрийн дундаж агуулга <sup>1</sup>	г/т алт	3.73	3.46
Төслийн хугацаа <sup>2</sup>	жил	7	4



Уурхайн ашиглалтын хугацаа	жил	6	3
Өдөрт боловсруулах хүдрийн хэмжээ <sup>3</sup>	тонн	1,800	1,800
Жилд үйлдвэрлэх алтны дундаж хэмжээ <sup>4</sup>	унц	61,000	48,000
Жилд үйлдвэрлэх алтны дээд хэмжээ <sup>4</sup>	унц	75,000	53,200
Ашиглалтын хугацааны дундаж металл авалт	%	91%	67%
Хөрс хуулалтын харьцаа ("Strip Ratio")	тонн:тонн	10.2	7.6
<b>Үйл ажиллагааны зардал</b>			
Уурхайн ашиглалтын хугацаанд ("LOM") бэлэн мөнгөөр нэгжийн өртөг <sup>5</sup>	US\$/унц	741	929
Нэг унц алтны нийт нэгжийн өртөг ("AISC") <sup>5</sup>	US\$/унц	746	931
<b>Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд, татварын өмнөх бодит үнэ цэн</b>			
5% хорогдуулалттай ("NPV5%")	сая ам.дол	124	31
7.5% хорогдуулалттай ("NPV7.5%")	сая ам.дол	107	24
10% хорогдуулалттай ("NPV10%")	сая ам.дол	92	19
<b>Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд, татварын дараах бодит үнэ цэн</b>			
5% хорогдуулалттай ("NPV5%")	сая ам.дол	97	24
7.5% хорогдуулалттай ("NPV7.5%")	сая ам.дол	83	19
10% хорогдуулалттай ("NPV10%")	сая ам.дол	71	15
Татварын өмнөх дотоод өгөөжийн түвшин ("IRR")	%	48%	110%
Татварын дараах дотоод өгөөжийн түвшин ("IRR")	%	42%	92%
Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил	1.8	1.1
<b>Капиталын нөхцөлүүд</b>			
Анхны хөрөнгө оруулалт (болзошгүй зардлууд тооцсоноор)	сая ам.дол	39.9	2.2
Ашиглалтын хугацааны хөрөнгө оруулалтуудын зардал	сая ам.дол	2.5	-

**Тэмдэглэл**

(1) Боловсруулах үйлдвэрийг тэжээх хүдрийн дундаж агуулга

(2) Төслийн хугацаанд уурхай байгуулах 1 жил, олборлолт хийх 9 жил болон уурхайн хаалтын 1 жил багтсан

(3) Үйлдвэр нь жилд 8,000 цаг ажиллаж, жилд 600,000 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай байна

(4) Баян Хөндий нь зөвхөн алтаар, Алтан Нар нь алттай дүйцэх нэгжээр хэмжигдсэн бөгөөд алттай дүйцэх нэгжийг тооцоолохдоо нэг унц алтыг US\$1,300, мөнгийг US\$17.50 үнээр төсөөлсөн. Өнөөгийн боловсруулалтын загварчлалаар хар тугалга болон цайрыг боловсруулах боломжгүй тул тооцоололд оруулаагүй болно.

(5) Үйл ажиллагааны зардал нь Баян Хөндий дээр алтны унц, Алтан Нар нь алттай дүйцэх унцаар тайлагнасан, үүнд \$77/унцаар тооцолсон Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр ("AMHAT") болон бусад шимтгэл зардлууд багтсан.

Доорх хүснэгтэд алтны үнээс шалтгаалан өнөөгийн үнэ цэн ("NPV") болон дотоод өгөөжийн түвшин ("IRR") хэрхэн өөрчлөгдөхийг харуулав. Үзүүлэлтүүд алтны үнийн өсөлт бууралт нь төслийн үр дүнд хэрхэн нөлөөлөхийг харуулав.

**Техникийн тайлангийн мэдрэмтгий байдал – Татварын дараах алтны үнийн мэдрэмтгий чанарын судалгаа – Баян Хөндий урьдчилсан ТЭЗҮ**

Алтны үнийн мэдрэмтгий чанарын судалгаа	Нэгж	\$1,200	\$1,300	\$1,400	\$1,500	\$1,600	\$1,700
NPV (5% хорогдуулалттай)	Сая ам.дол	73	97	121	144	165	188
NPV (7.5% хорогдуулалттай)	Сая ам.дол	61	83	105	125	145	165
NPV (10% хорогдуулалттай)	Сая ам.дол	50	70	91	109	128	146
IRR	%	34%	42%	50%	58%	66%	73%

**Техникийн тайлангийн мэдрэмтгий байдал – татварын дараах алтны үнийн мэдрэмтгий чанарын судалгаа – Алтан Нар АШЭТ**

Алтны үнийн мэдрэмтгий чанарын судалгаа	Нэгж	\$1,200	\$1,300	\$1,400	\$1,500	US\$1,600	US\$1,700
NPV (5% хорогдуулалттай)	Сая ам.дол	18	24	30	37	43	49
NPV (7.5% хорогдуулалттай)	Сая ам.дол	14	19	24	29	34	39
NPV (10% хорогдуулалттай)	Сая ам.дол	11	15	19	23	28	32
IRR	%	71%	92%	113%	134%	154%	173%

Баян Хөндийн Урьдчилсан ТЭЗҮ-д тусгагдсанаар, жилд 600,000 тонн хүдрээр үйлдвэрийг тэжээх хүчин чадал бүхий ил уурхайг төлөвлөж байна. Олборлох боломжтой хэмжээг 3.5 сая тонн, үүнд 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдэр багтсан бөгөөд хөрс хуулалтын харьцаа 10.2:1 байна (тонн хаягдал: тонн үйлдвэр тэжээх хүдэр). Хүдэржилт нь газрын дөт гүнд буюу хүдрийн дийлэнх хэсэг нь газрын гадаргаас доош 100 метрийн гүнд байна. Ордын бүтэц, агуулга болон гүнээс шалтгаалан ил уурхайн аргаар ашиглах боломжтой. Одоогийн төлөвлөж буй ил уурхайгаас доош далд уурхайн ашиглалт нь ТЭЗҮ-д багтаагүй бөгөөд ирээдүйд судалгаа хийгдэх боломжтой. Ашиглалтын үед урвуу хутгуурт гидравлик экскаватор ашиглана. Тэсэлсэн хөрс, материалыг автосамосвалд ачин, хаягдал материалыг уурхайтай залгаа орших хаягдлын овоолгод хуримтлуулан, хүдрийг боловсруулах үйлдвэрийн дэргэдэх тээрэм рүү шилжүүлнэ.

Алтан Нарын АШЭЗТ нь мөн ил уурхайн үндсэн үзүүлэлтүүд дээр үндэслэгдсэн ба жилд 600,000 тонн хүдрээр үйлдвэрийг тэжээх байдлаар төлөвлөсөн. Олборлох боломжтой хэмжээг 1.8 сая тонн, үүнд 3.46 г/т алт болон 17 г/т мөнгөний дундаж агуулга бүхий хүдэр багтсан бөгөөд хөрс хуулалтын харьцаа 7.6:1 байна. Алтан Нар орд нь хүдэр боловсруулах үйлдвэрээс 20 км зайд орших тул олборлосон хүдрийг газраар Баян Хөндий рүү тээвэрлэнэ.

Урьдчилсан ТЭЗҮ-д хүдрийг боловсруулахдаа уламжлалт буюу гравитациар баяжуулан, нүүрстэй уусгах технологиор алтыг ялгаж авахаар төлөвлөсөн. Хүдэр боловсруулах үйлдвэрийг Баян Хөндийн ил уурхайтай зэрэгцээ барих бөгөөд өдөрт 1,800 тонн хүдэр, жилд 600,000 тонн хүдэр боловсруулна. Уурхайн ашиглалтын хугацаанд 3.73 г/т дундаж агуулга бүхий нийт 3.5 сая тонн хүдрийг боловсруулна. Төслийн хугацаанд дундаж металл авалт 91% байх бөгөөд Баян Хөндий ордоос нийт 382,000 унц алт үйлдвэрлэнэ.

Алтан Нарын АШЭЗТ-ын хувьд, Алтан Нараас олборлосон хүдрийг Баян Хөндийн боловсруулах үйлдвэрт зөөн боловсруулах ба мөн адил уламжлалт буюу гравитациар баяжуулан, нүүрстэй уусгах технологиор алтыг ялгаж авна. Алтан Нар ордын ашиглалтын хугацаанд 3.46 г/т алтны дундаж агуулга, 17 г/т мөнгө бүхий 1.8 сая тонн хүдрийг Баян Хөндийн боловсруулах үйлдвэрт боловсруулна. Алтан Нард хүнцлийн колчеданы хүдэр багтаж байгаа тул ордын хүдрийг боловсруулалт хийснээр алт авалт дунджаар 67%, мөнгө авалт 62% байх боломжтойг харуулсан. Алтан Нар ордоос ашиглалтын хугацаанд нийт 136,000 унц алт, 616,000 унц мөнгө олборлох боломжтой бөгөөд алттай дүйцэх нэгжээр 144,000 унц олборлох боломжтойг тооцоолсон.

Үйл ажиллагааны зардлыг дээр дурдсан олборлолтын болон боловсруулалтын хувилбарууд дээр үндэслэн тооцоолохдоо гэрээт олборлогчтой ажиллахаар төлөвлөв. Бусад бүх үйл ажиллагааг компани өөрөө хариуцан ажиллана. Баян Хөндий төслийн хувьд унц алт үйлдвэрлэх нэгжийн өртөг \$714 ам.доллар, Алтан Нарын хувьд алттай дүйцэх нэгжээр \$931 ам.доллар байхаар тооцоолсон.

	Баян Хөндий Урьдчилсан-ТЭЗҮ			Алтан Нар АШЭЗТ		
	LOM (сая ам.дол)	ам.дол/ унц	ам.дол/ тонн	LOM (сая ам.дол)	ам.дол/ унц AuEq	ам.дол/ тонн
Уурхайн үйл ажиллагааны зардал	125	327	35	59	406	32
Боловсруулалтын зардал	113	295	32	56	388	31
Ерөнхий ба захиргааны зардал	15	40	5	8	60	5
Нийт үйл ажиллагааны зардал	253	662	72	123	854	68
АМНАТ болон бусад хураамжууд	30	77	8	11	77	6
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт болон уурхайн хаалтын зардал	2	7	1	-	-	-
Нийт зардал	285	746	81	134	931	74

Уурхай байгуулалт, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны хөрөнгийн зардлыг (0 жилд) 40 сая ам.доллар хэмээн тооцоолсон. Хэрэв түрээсийн тоног төхөөрөмжийг худалдан авах шаардлага гарвал хөрөнгийн зардал дээр 16 сая ам.доллар нэмэгдэнэ. Боловсруулах үйлдвэр болон холбогдох байгууламжууд Баян Хөндий төслийн талбайд байрлана.

6 дахь жилээс эхлэн Алтан Нартай холбох зам зэрэг дэд бүтцийг байгуулах бөгөөд энэ нь 2.2 сая ам.долларын өртгөөр бүтэх бөгөөд дээрх бүх зардлууд дээр нэмж 20% болзошгүй зардал багтсан.

Урсгал хөрөнгө оруулалтад 1.2 сая ам.доллар, уурхайн төлөвлөлт ба хаалтад 1.3 сая ам.долларыг тусгаснаар Хөндий Алтны Төслийн ашиглалтын хугацааны нийт хөрөнгийн зардлыг 44.6 сая ам.доллар хэмээн тооцов.

	Баян Хөндий Урьдчилсан ТЭЗҮ (\$ сая ам.дол)	Алтан Нар АШЭЗТ (\$ сая ам.дол)
Уурхай	1.9	1.3
Баяжуулах үйлдвэр	12.1	0.1
Барилга байгууламж	3.9	-
Байр, орон сууц	1.4	-
Төслийн үйлчилгээ	2.2	-
Газар шорооны ажил	3.0	0.3
Инженерчлэл болон бусад	4.3	-
Олборлолтын өмнөх зардал	10.9	0.5
<b>Үйлдвэр болон дэд бүтэц</b>	<b>39.9</b>	<b>2.2</b>
Уурхайн хаалт	1.3	-
Урсгал хөрөнгө оруулалт	1.2	-
<b>Нийт</b>	<b>42.4</b>	<b>2.2</b>

Хөндий Алтны Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжууд:

- Баян Хөндийн нөөцийг тэлэх: Баян Хөндийн нөөцийн тооцоололд нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн нөөц рүү шилжүүлэх боломжтой 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит геологийн нөөц багтсан. Түүнээс гадна ордоос баруун өмнөд бүсэд суваг малталт, өрөмдлөгийн үр дүнд өндөр агуулгыг тодорхойлсон бөгөөд олборлолтын эхэн үед өрөмдлөгийн цооног хоорондын зайг багасгаж өндөр агуулга бүхий нөөц үргэлжилж буйг баталгаажуулбал, нөөцийг нэмэгдүүлэх боломжтой. Ордын хойд зүгт хийсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр нөөцийн хязгаараас гадна өндөр агуулга бүхий (50 г/т-оос өндөр) интервалыг огтолсон нь ирээдүйд эрдэсжсэн бүсийг тэлэх боломжтойг илэрхийлнэ.
- Алтан Нарын нэмэлт нөөц: Анхан шатны эдийн засгийн тооцоололд тусгагдсан нөөц нь Алтан Нарын нөөцийн тодорхой хэсэгт тулгуурласан. Цаашид металлургийн судалгаагаар алт болон мөнгө авалтыг нэмэгдүүлэх судалгааг хийснээр нэмэлт нөөцийг эдийн засгийн тооцоололд багтаах боломжийг судална.
- Хайгуулын боломж: Баян Хөндий болон Алтан Нар ордууд нь хайгуул бага хийгдсэн, хэтийн төлөв өндөр бүсэд оршдог. Ордоос 5 км бүсэд дөт гүнд хийгдсэн өрөмдлөг болон гадаргын дээжлэлтээр хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон. Алтан нарын 5.6\*1.5 км бүхий хэтийн төлөвтэй бүсүүд нь гүндээ нээлттэй байна. Хоёр ордын бүрэн нөөцийн боломжийг тодорхойлоход нэмэлт хайгуулын ажил хийж гүйцэтгэх шаардлагатай.
- Геотехникийн судалгаа: Баян Хөндийн уурхайн ханын налууг тодорхойлохдоо инженерүүд уламжлалт аргыг хэрэглэхээр тогтсон. Геотехникийн 2019 оны 4-р улиралд тооцоолсон нэмэлт өрөмдлөгт үндэслэн уурхайн налуугийн өнцгийг бодитоор тодорхойлох боломжтой ба ингэснээр хөрс хуулалтын харьцаа ба олборлолтын зардлыг бууруулах боломжтой.
- Металл авалтыг нэмэгдүүлэх: Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д металл авалтыг 91% хэмээн тусгасан боловч металл авалт дунджаар 93% байна. Мөн өндөр агуулга бүхий хүдрийг уусгах аргаар шалгаж үзсэн бөгөөд металл авалт нь одоогийн хүдрийн 93%-99% (22 г/т-оос өндөр ба маш өндөр агуулга бүхий материал) хүртэл болж өсөх боломжтой. Нэмэлт металлургийн судалгаа 2019 оны 4-р улиралд хийгдсэн нь металл авалтыг нэмэгдүүлэх боломжтой.
- Өндөр агуулга: Баян Хөндий орд нь өндөр агуулга бүхий орд тул цаашид олборлолтын шатанд тооцоолсноос өндөр агуулгатай бүсийг нээн илрүүлэх магадлалтай.
- Уурхайн төлөвлөлт: Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын АШЭЗТ-оор Хөндий Алтны Төслийн олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх талаар эхний алхмуудыг танилцуулсан. Цаашид уурхайн төлөвлөлтийг сайжруулах, хаягдал зөөвөрлөлт, бохирдлыг бууруулах, ашиглалтын техникийн аргачлалыг сайжруулах зэргээр зардлыг бууруулах боломжийг судална.
- Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт: Голлох бус тоног төхөөрөмжийг 2-р зэргийн ханган нийлүүлэгчээс авч хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг бууруулах аргыг судална.

## **Дүүргийн хэмжээний хайгуул**

Эрдэнэ Ресурс нь Эдрэнгийн Нурууны дагуу тусгай зөвшөөрлийн талбайд эрдэсжсэн бүсэд хайгуулын боломжийг эрэлхийлэн ажилласаар байна. Энэхүү хайгуулын хөтөлбөрийн дагуу Компанийн 6 тусгай зөвшөөрлийн талбайд хэд хэдэн хэтийн төлөв бүхий хайгуулын талбайг илрүүлэн өрөмдлөгийн ажлыг эхлүүлэх, сонгон шалгаруулалтын хүрээнд нэмэлт талбайн тусгай зөвшөөрлийг Засгийн Газраас авах зэрэг ажлуудыг төлөвлөсөн.

Тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн хайгуулын ажлын хүрээнд алтны эрдэсжсэн бүсүүдийг нээн илрүүлээд байна. Өрөмдлөгийн ажлаар нийт цооногийн 70% нь алтны эрдэсжилт бүхий гажилтыг огтолсон ( $>0.1$  г/т алтны агуулгатай), үүнээс гуравт нь 20 г/т алтны агуулгатай 1-2 метрийн интервалууд илэрсэн. Бүс нутгийн хайгуулын өрмийн судалгааг газрын дөт гүнд буюу дунджаар 100 метр гүнд хийсэн. Орчин үеийн хайгуулын судалгаа хийгдээгүй бүсэд газрын гадаргад хийсэн геохимийн болон геофизикийн судалгааны эерэг дүнд тулгуурлан энэхүү өрмийн судалгааг хийх болсон. Компанийн өнөөгийн илрүүлээд буй гурван ордын газрын гадаргад ойр байрлал болон бусад хайгуулын талбайнуудад хийсэн гадаргын судалгааны үр дүн зэрэг нь энэхүү шинэ дүүргийн ирээдүйн геологийн боломж, хэтийн төлөвийг тодорхойлж байна.

### **Өмнөд Баян Хөндий**

Өмнөд Баян Хөндий нь Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд, Баян Хөндий алтны ордоос баруун өмнө зүгт 350 метрт байрладаг. Энэхүү хайгуулын талбайг 2019 оны эхээр хийсэн нөөц тэлэх өрөмдлөгөөр өндөр агуулга бүхий алтны хүдэржилтээр (51 г/т алтны агуулга хүртэл) илрүүлсэн бөгөөд ВКD-266 цооног нь одоогийн Баян Хөндийн нөөцийн хязгаараас гадна бөгөөд 264 метрийн гүнд хийсэн өрөмдлөгөөр тодорхойлсон.

Энэ шинэ хайгуулын талбайгаас өмнө зүгт үргэлжлүүлэн судалгаа хийхэд хувирлын бүс нь өмнө зүгт 500 метрт геофизикийн судалгаагаар газрын гадаргад ойр үргэлжилж буйг тодорхойлсон. 3-р улирлын өрөмдлөгтэй зэрэгцэн (ВКD-269) Баян Хөндий ордтой адил 100 метр нягт үелэн хувирсан галт уулын туйфыг огтолсон бөгөөд 100 метрийн гүнд алт агуулсан туйф нь 2.45 г/т алтны агуулга бүхий 1 метр ( $>0.1$  г/т)-ийн интервал огтолсон. Энэхүү нээлтээр ордын өмнө зүгт нэмэлт хайгуул хийж, эрдэсжсэн бүсийг тэлэх боломжтойг харуулж байна.

### **Алтан Сум**

Алтан Сум талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн гол хэсэгт Баян Хөндий ордоос хойд зүгт 4.5 км зайд оршдог. Энэхүү талбайн өрөмдлөгийн судалгаа нь талбайн гол структурын өндөр агуулгыг огтолсон өмнө бүсэд төвлөрсөн, үүнд 39 г/т алтны агуулга бүхий 1м интервал, 70 г/т алтны агуулга бүхий 2м интервал огтлогдсон. Алтан Сумд өрөмдсөн нийт 21 цооногийн (2,605 тууш метр) 77% нь алтны эрдэсжилт огтолсон.

Өрөмдлөгийн судалгаагаар нийт 1.2 км (суналын дагуу нээлттэй) урттай талбайд алтны эрдэсжсэн коридорыг үүсгэж буйг тогтоосон бөгөөд хүдрийн биет байх магадлалтай хэсгээс өмнө зүгт 400 метрт мөн алтны эрдэсжилт илрүүлээд байна. Мөн өмнөд хэсэгт байх структурын салааг өрөмдсөн өрөмдлөгийн ажлаар 0.2-2.6 г/т алтны агуулгатай мөнгө, молибден, хар тугалга, цайр болон сурьмагийн аномаль агуулгуудтай эрдэсжилтийг (AAD-25) ойролцоогоор 100 метр бодит гүнд огтолсон. Хайгуулын судалгааны үр дүнгээс үзэхэд дүүрэг дэх алтны эрдэсжилт нь структурын огтлол болон тэлэх чадвар бүхий гол бүсүүдээр хянагдсан байна. Эдгээр бүсүүд нь хувирлаас үүдэлтэй магнетитийн задралтай холбоотой, соронзон шинж чанар багатай бүсүүдийг бий болгосон. Компани нь ирээдүйд хийхээр төлөвлөсөн өрөмдлөгийн ажлаас урьтаж Алтан Сумын хувирлын бүсүүдэд өндөр нягтаршил бүхий соронзон хайгуул, IP туйл, татах хүчний мэдээллийн санг багтаах дэлгэрэнгүй геофизикийн тайллыг хийж гүйцэтгэж байна.

### **Хойд Хөндий**

Хойд Хөндий талбай нь Баян Хөндий ордоос зүүн хойд зүгт 4 км-т оршдог бөгөөд 2018 онд анхны өрөмдлөгийн судалгаа хийсэн. 2017 онд хийсэн гадаргуун хайгуулын зураглалын үр дүнд энэхүү талбайг илрүүлсэн бөгөөд 650 метр урт үргэлжлэх структураар хянагдсан кварцын штокверк болон брекчийн судлын бүсээс дээжилсэн кварцын судлын биетэд 22 г/т хүртэл өндөр агуулга бүхий алтны хүдэржилт илэрсэн. Дунджаар 93 метрийн босоо гүнтэй нийт 970 тууш метрийн урттай 6 цооногоор тус структурыг шалгаснаас 3-ыг нь урд хэсэгт, 2-ыг нь хойд хэсэгт 500 метрийн зайтайгаар өрөмдсөн. Хойд хэсэгт хийсэн өрөмдлөгийн үр дүнгээр зөвхөн бага хэмжээний алтны эрдэсжилтийг огтолсон бол урд хэсэгт өрөмдсөн цооногууд нь олон үе шаттай эпиптермаль кварцын штокверк болон брекчийг хувирсан монзонитод огтолсон. Эдгээр штокверк бүсүүд нь тасралтгүй үргэлжлэх ба 35 м хүртэлх

зузаантай (AAD-29) бөгөөд зарим хэсэгт 1 метрийн зузаалаг бүхий 2.1 г/т (AAD-30) хүртэлх алтны аномаль утга мөн хэсэгчлэн тохиолдох зэсийн аномаль (>500ppm) илэрсэн. 2019 оны 3-р улиралд Хойд Хөндийд 253 метр өрөмдлөг хийсэн (AAD-38) нь гүндээ кварц брекч биет үргэлжилж буйг судлах зорилготой байв. Сорьцлолтын үр дүнд 2 метрийн турш 0.25 г/т алтны агуулга бүхий гажилт байгааг тодорхойлсон. Алтны гажилт нь цооногт бүхэлд нь огтолсон кварц штокверкийн судлуудыг интервалуудтай холбоотойг илрүүлсэн.

### **Хар Морь (Dark Horse) (Шинэ нээлт)**

Хар Морь талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд, Баян Хөндий алтны ордоос зүүн-хойд зүгт 4.5 км-т, Алтан Сум хайгуулын талбайн зүүн-өмнөд зүгт 1 км-т оршдог. Хар Морь талбайг 2019 оны 4-р улиралд кварцын штокверк судлаар зүсэгдсэн массив турмалиныг дээжлэн, 32.9 г/т алтны агуулгатай болохыг тогтоосноор анх нээн илрүүлсэн. 2019 оны 4-р улиралд нэмэлт гадаргуун хайгуул буюу геологийн зураглал, геохимийн судалгааг (чулуун болон хөрсний дээжлэлт) хийсэн бөгөөд үүнээс бш чулуун дээжинд буюу сиенитийн порфирийг зүссэн комб кварц-адуларын судалд 5 г/т-оос 87.8 г/т хүртэлх алтны агуулга илэрсэн. 2019 оны 4-р улиралд гүйцэтгэсэн хайгуулын ажил нь Хар Морь талбайг баруун зүгт 1.5км x 2км болгон тэлснээр зэргэлдээ орших Алтан Сум алтны хэтийн төлөв бүхий талбайтай залгагдсан.

2019 оны 4-р улиралд хараат бус мэргэжилтнүүд геофизикийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Энэхүү үнэлгээний үр дүнд Алтан Сум талбай ба түүнтэй залгаа орших Хар Морь талбайн ирээдүйн хэтийн төлөв бүхий хайгуулын бүсийг тодорхойлох татах хүчний 3D загварчлал, татах хүч болон соронзон орны загварчлалыг багтаасан болно.

### **Улаан зэс-алтны порфирын төсөл**

Компани нь 2017 оны 8-р сарын 30-нд Баян Хөндий алтны төслийн баруун зүгт орших Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн 51%-ийг 100% хүртэл худалдан авах нөхцөлтэйгөөр худалдан авсан. Улаан талбай нь 1,780 га талбайг хамардаг бөгөөд 3 км диаметр бүхий гүндээ зэсийн порфир болон эпитеpmаль алтны системтэй холбоотой байж болохуйц хүчтэй хувирсан бүсийг агуулдаг. Энэ хайгуулын тусгай зөвшөөрөл нь хайгуулын тусгай зөвшөөрлийн 12 жилийн 6 дахь жилдээ явж байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой. Энэхүү төслийн 51%-ийг худалдан авах гэрээ байгуулснаас хойш 3 жилийн турш \$600,000 ам.долларын хайгуулын судалгааг хийсэн тул үлдсэн 49%-ийг зах зээлийн үнэлгээгээр худалдан авах эрх үүссэн. Эрдэнэ Ресурс жилд \$100,000 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулснаар 49%-ийг худалдан авах эрхийн хугацааг сунгах боломжтой.

Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадарга дээр 5км x 4км хэмжээтэй филлик хувирлын (кварц-серицит-пирит) өргөн бүс үүсгэсэн порфирын хэтийн төлөвтэй талбай хэмээн ойлгогддог. Улаан талбайд гадаргуун чулуун дээжлэлт болон урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийн, алт, зэс болон молибденийн хэд хэдэн хуримтлал бүхий гажил байгааг тогтоосон. Мөн геофизикийн судалгаа хийж цаашид үргэлжлүүлэн судлах хэд хэдэн хэтийн төлөвт бүсийг тогтоосон.

Энэхүү талбайд 2018 онд хайгуулын өрөмдлөг хийсэн бөгөөд тусгай зөвшөөрлийн төв хэсэгт 1.3 км талбайд нийт 1,050 тууш метрийн урттай 3 цооногийг өрөмдсөн. Гурван цооног гурвуулаа галт уулын чулуулагт хэсэгчлэн орших, зэсийн бага агуулгатай кварц-пиритийн зэрэгцээгээс штокверк судлуудыг огтолсон ба мөн газрын гадарга дээрх пропилитийн хувирлаас газрын гүн дэх филлик (кварц-серицит-пирит) хувирлын тодорхой ялгагдах бүсчлэлийг огтолсон. (60 метрийн турш 100 - 300ppm)

2019 оны 4-р улиралд нийт 700 тууш метрийн өрөмдлөгийн ажил хийн, гурван цооног өрөмдсөн. Энэ нь хувирлын бүсийг гүндээ шалгах (650 метр хүртэл), урьдын цооногийг үргэлжлүүлэн судлах болон дөт гүний хоёр хайгуулын цооногийн IP туйлшралыг шалгахар өрөмдсөн (200 метр хүртэл). Үргэлжлэн өрөмдсөн цооногийн үр дүнд вулканик-субвулканик чулуулагт ангидрит-кварцмагнетитын судалжилт ихтэй филлик төрлийн хувирал гүнд үргэлжилж буйг тогтоосон. Сунгаж өрөмдсөн цооногт нь филлик маягийн хувирал үргэлжилсэн бөгөөд гүндээ зэсийн агуулга өндөрсөж 130 ppm зэсийн агуулгатай 22 метр огтолсноор хаасан. Тус цооног нь бүхэлдээ серицитийн хувирал болон пиритийн хүдэржилттэй агуулагч андезит байсан ба зарим хэсэгт нь турмалины хувирлын бүсүүд болон кварцын судалжилт тогтоогдсон. Геохимийн аномаль тус цооногт илрээгүй. Эцсийн цооног нь нь 140-өөс 202 метрийн (цооногийн төгсгөл) гүнд алт агуулсан кварц-турмалины брекч болон брекч судалтай турмалин-цахиур-серицитийн хувирлын бүс байгааг илрүүлсэн. Алт агуулсан аномаль интервалууд: 1.3 г/т алтны агуулга бүхий 2 метр, 0.29 г/т алтны агуулга бүхий 4 метр, 0.5 г/т алтны агуулга бүхий 2 метр, 0.23 г/т алтны агуулга бүхий 2 метр, 0.15 г/т алтны агуулга бүхий 40 метрийн интервал илэрсэн. Тус аномаль бүсэд >400 ppm хүртэл зэсийн хүдэржилт илэрсэн. Эрдэнэ

Ресурсийн техникийн баг нь эдгээр шинэ үр дүнгүүдийг талбайн геологи, геохими, геофизиктэй холбон тайлал хийн, ирээдүйд Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэх өрөмдлөгийн ажлыг тодорхойлохоор ажиллаж байна.

### **Зуун Мод молибденийн төсөл**

Зуун Мод молибденийн төсөл нь молибден-зэс порфирын орд бөгөөд Монголын баруун өмнөд хэсэгт оршино. Улаанбаатар хотоос баруун урд зүгт ойролцоогоор 950 км, Монгол-Хятадын хил дээрх Цэхийн галт тэрэгний боомтоос 215 км зайд байрладаг. Энэ өртөө нь Нарийн Сухайт болон Овоот Толгойн нүүрсний уурхайгаас урд зүгт 50 км-т байрладаг. Төсөл нь нийт 6,041 га талбай бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Энэ ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Компанийн охин компани болох Аниан Ресорсиз ХХК-ийн эзэмшилд байдаг ба ашиглалтын тусгай зөвшөөрөл нь эхний 30 жилийн хугацаанд явж байна. Энэ төслийг Галлант Минералз Лимитэд компаниас 2005 онд авсан бөгөөд Галлант Минералз компанид буцаан худалдаж авах нөхцөлтэйгээр 1.5%-ийн нөөцийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн.

Компани нь 2011 оны 2-р улиралд NI 43-101 стандартын дагуу Зуун Модын нөөцийг тооцоолон олон нийтэд ил болгосон. Захын агуулгыг 0.04% молибден гэж тооцон, дунджаар 0.057% молибден болон 0.069% зэсийн агуулгатай 218 сая тоннын (“Mtn”) баталгаатай ба бодит нөөцтэй гэж тооцоолсон. Энэ нь 273.5 сая фунт металл молибден агуулсан болон 330.7 сая фунт металл зэстэй тэнцэнэ. Үүнээс гадна Зуун Модод дунджаар 0.052% молибден болон 0.065% зэсийн агуулгатай 168 сая тн таамаг нөөц байгаа ба энэ нь 191.8 сая фунт металл молибден агуулсан болон 240.5 сая фунт металл зэс агуулсан байдалтай байна.

Молибденийн энэхүү төсөл нь молибденийн үнэ өсөх үед хөгжүүлэлт хийх бүрэн боломжтой төсөл юм. 2017 онд фунт тутам нь \$7.25 болон огцом унаж байсан молибденийн үнэ 2019 онд өсч \$11.00 болсон. Молибденийн зах зээлийн үнийн өсөлт нь Зуун Мод молибден-зэсийн ордыг хөгжүүлэх чухал хүчин зүйл болох бөгөөд технологи болон/эсвэл хайгуултай холбоотой нэмэлт мэдээлэл гармагц төслийн эдийн засгийн оновчлолын үнэлгээг үргэлжлүүлэн хийнэ. Хөвийн Хар төсөлд зэсийн тодорхой хэмжээний нэмэлт хүдэржилт илрүүлснээр Зуун Мод молибденийн ордыг хөдөлгөх хөшүүрэг болох боломжтой.

Зуун Мод ордын нөөцийн тайланг SEDAR-т байршуулсан бөгөөд "Technical Report Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, South-Western Mongolia, National Instrument 43-101 Independent Technical Report" нэртэйгээр 2011 оны 6-р сард бүртгүүлсэн.

### **Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл**

Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл нь Зуун Мод ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байх ба Зуун Мод молибден-зэсийн порфирийн ордоос баруун хойд зүгт 2.2 км зайд байрладаг. Хөвийн Хард геологийн зураглал, судлын нягтаршлын зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн судалгаа болон хол алслалтай өрөмдлөгийн ажлуудыг хийсэн. Өмнө нь хийсэн геофизикийн гажилтай цэг шалгах өрөмдлөгийн судалгаагаар 308-342 метр гүнд 1.3% зэс болон 9.24 г/т мөнгөний агуулгатай 34 метрийн интервал (ZMD-121) огтолсон. Хөвийн Хард хийсэн нэмэлт өрөмдлөгийн ажлаар том хэмжээний буюу 900 метр үргэлжлэх, зэсийн хэд хэдэн эрдэсжсэн бүс байгааг илрүүлсэн. Өрөмдсөн гурван цооногт 0.2%-аас илүү зэсийн агуулгатай тодорхой интервалууд (12-42 метр) огтлогдсон.

### **Шинэ хөрөнгө оруулалт**

2018 оны 3-р улиралд Монгол Улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож эхэлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөвтэй талбайнуудыг тодорхойлсон. Энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна. Түүнээс гадна хувийн өмчийн хуулийн этгээдүүдтэй хэлцэл хийх замаар тусгай зөвшөөрлийн талбайг эзэмших боломжуудыг судалсаар байна.

### **Санхүүгийн тайлангийн онцлох мэдээлэл**

Доорх санхүүгийн мэдээлэлд 2018, 2019 оны 12 сарын 31-ний байдлаар аудитлагдсан, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг тусгав (Үнэт цаасны тоо хэмжээнээс бусад нь Канад доллараар илэрхийлэгдсэн).

<b>12 сарын 31-нд дуусгавар болсон</b>	<b>2019</b>	<b>2018</b>	<b>2017</b>
Орлого	Nil	Nil	Nil
Алдагдал	\$ 2,683	\$3,657	\$4,027

Нэгж хувьцаанд ногдох суурь ба хорогдуулсан алдагдал	\$ 0.02	\$ 0.02	\$ 0.03
Нийт хөрөнгө	\$ 26,973	\$ 17,709	\$ 14,946
Нийт урт хугацааны өр төлбөр	\$ 6,374	Nil	Nil

## Үйл ажиллагааны хэлэлцүүлэг

### 2018, 2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн мэдээлэл

Доорх хүснэгтэд 2018, 2019 оны 12 сарын 31-ний байдлаар хайгуул болон үнэлгээний зардлыг харуулав. Энэхүү хугацаанд компани Хөндий Алтны Төсөлд төвлөрч ажилласан.

2019.12.31 байдлаар	Хөндий Алтны Төсөл			Зуун Мод	Улаан ба бусад	Нийт
<b>Хайгуул, үнэлгээний зардал</b>						
Хайгуул, хээрийн ажлууд	\$ 1,486,384	\$ 113,782	\$ 490,087	\$ 2,090,253		
Уурхайн судалгаа, зөвшөөрлүүд	3,714,855	-	-	3,714,855		
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	292,804	292,804		
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	230,292	230,292		
Оролцогч талуудтай харилцах	270,537	-	4,597	275,134		
Томилолт ба бусад	63,359	-	28,217	91,576		
Нийт хайгуулын зардал	5,535,135	113,782	1,045,997	6,694,914		
Капиталжуулсан зардал	(5,535,135)	(67,091)	(1,902)	(5,604,128)		
<b>2019 онд зарлагдсан хайгуулын зардлууд</b>	\$ -	\$ 46,691	\$ 1,044,095	\$ 1,090,786		

<b>Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2019.01.01</b>	\$ 13,930,310	\$ 831,726	\$ 925,312	\$ 15,687,348
Нэмэлт	5,535,135	67,091	1,902	5,604,128
БЦАТ буцаан худалдан авалт	1,200,000	-	-	1,200,000
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(897,504)	(70,018)	(40,437)	(1,007,959)
<b>Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2019.12.31</b>	\$ 19,767,941	\$ 828,799	\$ 886,777	\$ 21,483,517

2018.12.31 байдлаар	Хөндий Алтны Төсөл			Зуун Мод	Улаан ба бусад	Нийт
<b>Хайгуул, үнэлгээний зардал</b>						
Хайгуул, хээрийн ажлууд	\$ 2,434,562	\$ 122,689	\$ 781,830	\$ 3,339,081		
Уурхайн судалгаа, зөвшөөрлүүд	1,343,667	-	-	1,343,667		
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	250,043	250,043		
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	473,150	473,150		
Оролцогч талуудтай харилцах	343,697	-	17,666	361,363		
Томилолт ба бусад	169,629	1,072	20,687	191,388		
Нийт хайгуулын зардал	4,291,555	123,761	1,543,376	5,958,692		
Капиталжуулсан зардал	(4,291,555)	(70,074)	(1,388)	(4,363,017)		
<b>2018 онд зарлагдсан хайгуулын зардлууд</b>	\$ -	\$ 53,687	\$ 1,541,988	\$ 1,595,675		
<b>Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2018.01.01</b>	\$ 9,700,832	\$ 765,795	\$ 928,216	\$ 11,394,843		
Нэмэлт	4,291,555	70,074	1,388	4,363,017		
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(62,077)	(4,143)	(4,292)	(70,512)		
<b>Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2018.12.31</b>	\$ 13,930,310	\$ 831,726	\$ 925,312	\$ 15,687,348		

2018 оны 12 сарын 31-нд хайгуул, үнэлгээний зардлууд \$5,958,692 байсан нь 2019 оны мөн үед \$6,694,914 болж өссөн.

Хайгуул ба хээрийн ажлуудын зардал 2019 онд \$2,090,253 болж, 2018 оны 12 сарын 31-ний \$3,339,081-ээс буурсан нь өрөмдлөг, хайгуулын ажлууд буурч, Компанийн техникийн ажилтнууд Хөндий Алтны Төслийн АШЭЗТ, Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын шинэчилсэн АШЭЗТ-ыг боловсруулахад төвлөрсөнтэй холбоотой. Гэвч уурхайн судалгаа, тусгай зөвшөөрлийн зардал нь 2019 оны 12 сарын 31-нд \$3,714,855 буюу 2018 оны мөн үеийн \$1,343,667-тэй харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Хайгуулын үйл ажиллагаа буурсантай холбоотойгоор томилолт ба бусад зардал нь 2019 онд \$91,576 болж буурав.

Монголын оффисийн зардал нь 2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцэст \$42,761 болж өссөн нь хууль эрхзүй, ажилтнуудын өөрчлөлт, засгийн газартай харилцах, маркетингийн зардал өссөнтэй холбоотой.

Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр нь 2019 оны 12 сарын 31-нд \$230,292 байсан нь 2018 оны мөн үеийн \$473,150-аас буурсан үзүүлэлт юм. Энэ нь 2019 онд Компанийн хувьцааны ханш буурсантай холбоотой.

Оролцогч талуудтай харилцахад зарцуулсан зардал нь 2019 оны 12 сарын 31-ний байдлаар \$275,134 буюу 2018 оны мөн үеээс \$86,229-аар буурсан үзүүлэлттэй байсан нь 2018 онд орон нутгийн худгийг засварлах, Бритиш Колумбийн их сургуультай хамтарсан судалгааг дэмжсэн зардал зэргүүд багтаж байна.

Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн Алтан Нар ордын анхан шатны нөөцийн тайланг хүлээн авснаар 2015 оны 1 сарын 1-нээс хойш Хөндий Алтны Төслийн хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. 2018, 2019 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон жилийн эцэст Компани нь дээрх төсөлтэй холбоотой бүх хайгуулын зардлуудыг капиталжуулсан.

	12 сарын 31-нд дуусгавар болсон		
	2019	2018	Өөрчлөлт
Захиргааны үйлчилгээ	\$ 373,799	\$ 535,118	\$ (161,319)
Элэгдэл, хорогдол	18,051	6,194	11,857
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр	178,409	132,841	45,568
Хөрөнгө оруулагчидтай харилцах, маркетинг	109,963	201,074	(91,111)
Оффис ба бусад	107,841	123,271	(15,430)
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	202,576	236,394	(33,818)
Зохицуулагч байгууллагын төлбөр	105,234	116,567	(11,333)
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	472,768	712,854	(240,086)
Томилолтын зардал	47,083	56,077	(8,994)
	\$ 1,615,724	\$ 2,120,390	\$ (504,666)

2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцэст захиргаа, удирдлагын зардал \$1,615,724 байсан нь 2018 оны мөн үеийн \$2,120,930-тэй харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Захиргааны үйлчилгээ 2019 оны эцэст \$373,799 байсан нь 2018 оноос \$161,319-ээр буурсан үзүүлэлт бөгөөд энэ нь ажилтнуудын өөрчлөлт, төв оффисийн ажилтнуудын цалингийн зардал 2019 онд техникийн судалгаа хийхээр ажилласан тул хайгуул ба үнэлгээний зардалд багтсанаас болж буурав.

ТУЗ-ийн гишүүдийн төлбөр нь 2019 онд \$178,409 байсан нь 2018 оноос \$45,568-аар өссөн нь ТУЗ-ийн дарга, Техникийн хорооны дарга зэрэг нь 2019 онд хийгдсэн техникийн судалгааг боловсруулахад хийж гүйцэтгэсэн ажлуудын зардал багтсан. Ажилтнуудын орон тоо өөрчлөгдсөн болон 2019 онд оролцсон хөрөнгө оруулагчдын хурлын тоо багассантай холбоотойгоор Хөрөнгө оруулагчидтай харилцах, маркетингийн зардал 2018 оноос \$91,111-оор буурсан үзүүлэлттэй байв.

Стратегийн санхүүгийн төлөвлөлт, хувьцааны ханш буурсантай холбоотойгоор зохицуулагч байгууллагын төлбөр буурсан, ЕСБХБ-ны хөрвөх нөхцөлтэй зээлтэй холбоотой санхүүжилтийн зардлыг хэсэгчлэн нөхсөн зэргээс үүдэн мэргэжлийн үйлчилгээний төлбөр \$202,576 буюу 2018 оноос \$33,818-аар буурсан үзүүлэлт байсан.

Бэлэн бус хувьцаанд суурилсан нөхөн төлбөр нь өнгөрсөн оны мөн үеэс \$240,086 буурсан нь 2019 онд Компанийн хувьцааны ханш буурч, бэлэн бус хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийн бодит үнэ цэнийн тооцоололд өөрчлөлт орсонтой холбоотой.

Элэгдэл, хорогдол, оффис болон бусад, томилолтын зардалд 2019 онд энэхүү тайланд тусгахаар материаллаг өөрчлөлт ороогүй.

## Дөрөвдүгээр улирал

2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд хайгуулын зардал \$2,200,619 байсан. Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын шинэчилсэн АШЭЗТ, эцсийн ТЭЗҮ боловсруулж эхлэх зэрэгт зориулан ашиглалтын судалгаа, тусгай зөвшөөрөлд \$1,307,937 долларыг зарцуулсан. 2019 оны хайгуулын хөтөлбөр нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Хар Морь талбайн геологийн зураглал, геохимийн дээж авах ажлууд, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд 1,369 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрөмдлөг, шуудуу



малталт, дээжлэлтийн судалгаа зэрэгт \$671,328 долларыг зарцуулсан. Бусад хайгуулын зардал томилолтын зардал, тусгай зөвшөөрлийн зардал болон Компанийн Монгол Улс дахь хээрийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий зардлууд багтан, \$221,354 болсон.

2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд ерөнхий болон захиргааны зардал \$429,177 доллар байснаас цалин болон захиргааны зардал \$151,853, зохицуулагч байгууллагын зардал болон бусад захиргааны зардлууд \$212,273, томилолт болон хөрөнгө оруулагчидтай харилцах зардал \$65,051 байсан.

2019 оны 4-р улиралд Компанийн санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээ үйл ажиллагааны тогтвортой байдалд материаллаг нөлөө үзүүлэх үйл явдал тохиолдоогүй.

## Улирлын үр дүнгийн хураангуй

*Хувьцааны тоо хэмжээнээс бусад дүнг мянган Канад доллараар илэрхийлэв.*

	Санхүүгийн жил 2019				Санхүүгийн жил 2018			
	Q4	Q3	Q2	Q1	Q4	Q3	Q2	Q1
	12 сар	9 сар	6 сар	3 сар	12 сар	6 сар	3 сар	3 сар
Алдагдал	\$773	\$638	\$755	\$517	\$773	\$743	\$1,439	\$702
Нэгж хувьцаанд ногдох алдагдал	\$0.01	\$0.00	\$0.01	\$0.00	\$0.01	\$0.00	\$0.01	\$0.00
Нийт хөрөнгө	\$26,973	\$20,942	\$19,365	\$19,632	\$17,709	\$18,136	\$19,500	\$14,879

2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд Компани нь \$772,935 долларын цэвэр алдагдалтай байсан ба 2018 оны мөн үед \$772,372 доллар байсан.

Компанийн зардал нь Монгол дахь хайгуулын хөтөлбөрүүдээс хамаарч улирал тутамд харилцан адилгүй байдаг. Компани нь өнгөрсөн хугацаанд санхүүгийн үр дүнд нөлөөлж болохуйц мэдээ болон тодорхой чиг хандлагын тухай мэдээлэл аваагүй болно.

## Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц

Энэхүү УХДШ гарах өдрөөр Компанийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор \$3.8 сая канад доллар байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компанийн Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, тэдгээрийг дэмжих захиргааны зардлуудыг санхүүжүүлэхэд зарцуулсан (Хайгуул, хөгжүүлэлтийн төслүүд ба Үйл ажиллагааны хэлэлцүүлгээс танилцана уу). Компанийн удирдлага 2020 оны 3-р улирал хүртэл компанийн төсөвт зардлуудыг санхүүжүүлэх боломжтой гэж үзэж байна. Компани нь өөрийн хайгуулын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх чадвар нь хөрөнгө борлуулах, түншлэл байгуулах, опцион болон хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах, хувьцааны санхүүжилт хийх болон/эсвэл зардал бууруулах зэргээр тодорхойлогдоно. Нэмэлт санхүүжилт хийх хугацаа, боломж, төлөвлөлт нь Компанийн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүн болон зах зээлийн нөхцөл байдлаас хамаарна.

Компанийн орлогын эх үүсвэр хязгаарлагдмал тул мөнгөн гүйлгээнд дүн шинжилгээ хийх эсвэл ямарваа нэг бодитой чиг хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй. Компани нь хайгуулын болон төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүдээ нэмэлт хувьцаа гаргах замаар хувьцааны санхүүжилт татан төвлөрүүлснээр санхүүжүүлж байна.

Энд дурдсанаас бусдаар Компани нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, урьдчилан тооцоолж болохуйц ирээдүйн капитал хөрөнгө материаллаг байдлаар өсөх/буурах аливаа чиг хандлага, шаардлага, үүрэг, үйл явдал, тодорхой бус байдлын талаар мэдээлэл байхгүй болно. Компанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, капитал хөрөнгийн өсөлт, бууралт нь Монгол Улс дахь хайгуул, төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүд амжилттай/амжилтгүй хэрэгжих, мөн хангалттай хувьцааны санхүүжилт татан төвлөрүүлэх чадвартай эсэхээс хамаарч тодорхойлогдоно.

## Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл

### Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

### Гаргасан ба эргэлтэд буй хувьцаат капитал

	2020.03.13	2019.12.31
Гаргасан ба эргэлтэд буй энгийн хувьцааны тоо	191,644,558	191,068,490
Опцион	12,355,000	12,305,000
Варрант	30,252,744	30,252,744
ИОХЭ	4,050,860	4,636,850
Нийт гаргасан санхүүгийн хэрэгсэл	238,303,162	238,263,084

### Гэрээгээр хүлээсэн үүрэг

Дараах хүснэгтэд 2019 оны 12 сарын 31-ний байдлаар Компанийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулав:

	Нийт	>1 жил	1-3 жил	4-5 жил	5< жил
Оффисын түрээс	\$162,090	\$34,480	\$ 69,215	\$ 58,395	\$ -
Дансны өглөг ба хуримтлагдсан өр төлбөр	591,999	591,999	-	-	-
	<b>\$754,089</b>	<b>\$626,479</b>	<b>\$ 69,215</b>	<b>\$ 58,395</b>	<b>\$ -</b>

### Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг

#### Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк

2019 оны 10 сарын 11-нд Эрдэнэ Ресурс нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ" буюу "European Bank for Reconstruction and Development" эсхүл "EBRD")-аас \$5 сая ам.долларын (\$6.6 сая кан.доллар) хөрвөх нөхцөлтэй зээл хүлээн авсан. 2019 оны 11 сарын 4-нд урьдчилгаа санхүүжилт 2.5 сая ам.долларыг хүлээн авч, 2019 оны 11 сарын 25-нд удаах санхүүжилтийг хүлээн авсан. Жилийн 10%-ийн хүүтэй энэхүү зээлийг Компанийн сонголтоор капиталжуулж болох бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болсноос 36 сарын дараа төлөгдөх нөхцөлтэйгээр эргүүлэн төлж болно, үүнд: (1) NI 43-101 стандартын дагуу хийгдсэн эцсийн ТЭЗҮ-ийг бүртгүүлэх эсвэл Эрдэнэ Ресурсийн хяналтын багц солигдох (2) анхны санхүүжилтийн гүйлгээ хийгдсэнээс хойш 24 сар өнгөрсөн. Холбогдох нөхцөлүүдийг хангаснаар нэг, хоёр, гурван жилийн хугацаанд EBRD нь бүх зээл болон хэсэгчлэн хөрвүүлэх сонголтыг хийсэн тохиолдолд нэгж хувьцааг \$0.20 канад доллар буюу жил тус бүр 10%, 20% болон 30%-ийн нэмэгдэл үнэлгээтэйгээр компанийн Энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой. Хөрвүүлэлтийн өдрийн капиталжуулагдсан хүүг ЕСБХБ-ны сонголтоор Компанийн энгийн хувьцааны зах зээлийн үнээр (5 өдрийн жигнэсэн дундаж ханш) бэлэн мөнгөөр эсвэл Компанийн хувьцаа хэлбэрээр төлнө. Компанийн төслүүдийг эзэмшдэг Монгол дахь охин компанийн хувьцаа нь зээлийн баталгаа болно.

#### Сэндсторм Гоулд ("Sandstorm Gold Ltd") Роялти гэрээ

2016 оны 4 сарын 21-нд Компани нь Сэндсторм Гоулд Лтд. ("Sandstorm") компанид Цэнхэр Номин (Алтан Нар) болон Хөндий тусгай зөвшөөрлүүдэд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг ("NSR") төлөх хэлцэл хийсэн. Сэндсторм нь Хөндий болон Цэнхэр Номингийн тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ирээдүйн роялти санхүүжилтэд хориг тавих эрхтэй. 2019 оны 4 сарын 12-нд Эрдэнэ Ресурс нь Сэндсторм ("Sandstorm Gold Limited")-д борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн 50%-ийг 1.2 сая кан.доллараар худалдан авч, борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг 1% хүртэл бууруулсан.

#### Бусад

2020 онд Алтан Нар, Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын зардалд хамгийн багадаа \$10/га ам.долларыг зарцуулах нөхцөлтэй (тус бүр \$46,690, \$22,050 ам.доллар).

Компани нь 2020 оны 8 сарын 30 хүртэл \$600,000 ам.долларын хайгуулын судалгааг хийж гүйцэтгэсэнээр (Улаан тусгай зөвшөөрлийн талбайд) Лидер Эксплорэйшн ХХК-ийн 49%-ийг тухайн

үеийн зах зээлийн үнэлгээгээр худалдан авах эрх үүсэх нөхцөлтэй байсныг Компани 2019 оны 12-р сарын 31 өдрийн байдлаар бүрэн гүйцэлдүүлсэн. Жилд \$100,000 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулснаар худалдан авах опционыг сунгах боломжтой. Эрдэнэ Ресурс нь хайгуулын ажлын зарцуулалтын хамгийн бага хэмжээг гүйцэтгэж чадаагүй нөхцөлд 51%-ийн өмчлөл нь Лидер Эксплорэйшн ХХК-д буцан шилжинэ.

Галлант Минералз Лимитед ("Gallant Minerals Limited") нь Компанийн Зуун Мод тусгай зөвшөөрлийн борлуулалтын цэвэр ашгаас 1.5%-ийн төлбөр ("БЦА") хүртэх эрхтэй. Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын судалгаа, ажил хийх үүрэг хүлээгээгүй.

## **Балансаас гадуурх зохицуулалт**

Компани нь 2019 оны 12 сарын 31-ний байдлаар батлан даалтын гэрээ, өөр бусад байгууллагад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой болзошгүй үүрэг, үүсмэл хэрэгсэл буюу Компанид санхүүжилт, хөрвөх чадвар, зах зээлийн болон зээлийн эрсдэл учруулж болзошгүй аливаа үүрэг гэх мэт балансаас гадуурх аливаа зохицуулалт хийгээгүй болно.

## **Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол**

### **Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх дүнгийн тооцоолол**

Үйл явдал, нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан тодорхой жилд үнэ цэн бууралтын гарз гарах буюу үнэ цэн бууралтын гарзын буцаах бичилт хийх шаардлага гарч болно.

Корпорацийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу санхүүгийн бус хөрөнгө буюу бэлэн мөнгө бий болгох нэгжийг тайлант жил бүр үнэлж, үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг шалгана. Хэрэв ийм шинж тэмдэг байгаа бол нөхөгдөх дүнг албан ёсоор тооцоолж, нөхөгдөх дүнгээс хэтэрсэн дансны үнээр үнэ цэн бууралтын алдагдлыг бүртгэнэ. Хөрөнгийн буюу бэлэн мөнгө бий болгох нэгжийн нөхөгдөх дүнг хөрөнгийн борлуулалтын цэвэр үнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль ихээр бүртгэнэ. Гүүдвэлийн зорилгоор жил бүр үнэ цэн бууралтыг шалгана.

Бодит үнэ цэнийг холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгө солилцож болох дүн гэж тодорхойлох ба ерөнхийдөө хэтийн төлөвт талбайг тэлэх, яваандаа данснаас хасах байдлаар хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаас үүсэхээр хүлээгдэж байгаа тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн юм. Ашиглалтын үнэ цэн гэдэг нь хөрөнгийг өнөөгийн хэлбэрээр нь тасралтгүй ашигласнаас болон ашиглахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж байгаа тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн юм. Өнөөгийн үнэ цэнийг тухайн хөрөнгөд агуулагдах эрсдэлүүдэд тохирох эрсдэлийн тохируулалттай татварын өмнөх хорогдуулагч ашиглан тодорхойлно.

Ирээдүйн мөнгөн урсгалын тооцоолол нь хүлээгдэж буй үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ (өнөөгийн болон түүхэн үнэ, үнийн чиг хандлага, холбогдох хүчин зүйлсийг харгалзана), нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээлтийн зардал, ирээдүйн капиталын зардалд тулгуурлана. Хөрөнгийн нөхөгдөх дүнд нөлөө үзүүлж болзошгүй төсөөлөл нь нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгдөх боломжтой тул энэхүү бодлого нь эрсдэл болон тодорхой бус байдалд өртөж болзошгүй эдгээр тооцоолол, төсөөллийг хийхийг удирдлагаас шаарддаг. Энэ тохиолдолд хөрөнгийн дансны үнэ бүхэлдээ буюу хэсэгчлэн буурч болох ба үнэ цэнийн бууралтыг орлогын тайлангаас хасна.

### **Хувьцаанд суурилсан төлбөр**

Ажилтнуудад олгосон өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөрийг олгосон өдрөөр бодит үнэ цэнээр (зах зээлд суурилаагүй баталгаажих нөхцөлийн нөлөөг тооцохгүй) бүртгэнэ. Бодит үнэ цэнийг Black-Scholes үнэлгээний загварыг ашиглан тооцох ба ингэхдээ бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд шийдвэр гаргаж үнэлэхийг шаарддаг. Компани 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хугацааны бэлэн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөрт нийт \$703,060 долларыг зарцуулсан (2018 - \$1,186,004).

### **Татвар**

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын татвартай холбогдох хэсэгт удирдлагын зүгээс тайлан балансад хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлж, шийдвэр гаргана. Ирээдүйд татвар ногдох хангалттай ашиг төвлөрүүлэх эсэхээс хамаарч нөхөгдөх боломжтой тохиолдолд л татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлснээс, капиталын алдагдал болон түр зөрүүгээс үүсэх хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйд татвар ногдох хангалттай ашиг төвлөрүүлэх тухай төсөөлөл нь ирээдүйн мөнгөн урсгалын

талаарх удирдлагын тооцооллоос хамаарна. Энэ бүхэн нь ирээдүйн үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ, нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээх зардал, капитал зардал, ногдол ашиг болон капиталын менежментийн бусад хэлцэл, гүйлгээнээс шалтгаална.

Түүнчлэн орлогын албан татварын хууль тогтоомжийн асуудлаар шийдвэр гаргах шаардлагатай. Нөхцөл байдлын өөрчлөлт нь тайлан балансад хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийн болон хойшлогдсон татварын өрийн дүн, хараахан хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа татварын бусад алдагдал болон түр зөрүүгийн дүнд нөлөөлж, хүлээгдэж буй үр дүнг өөрчлөх боломжтой тул эдгээр шийдвэр болон төсөөлөл нь эрсдэл болон тодорхой бус байдалд өртөх магадлалтай байдаг. Энэ тохиолдолд хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн тохируулалт хийхэд орлогын тайланд харгалзах хөнгөлөлт, төлбөр үүснэ.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн голлох тооцоололд сүүлийн 2 жилийн хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

## **Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт**

Компани нь 2019 оны 1 сарын 1-нээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарыг даган мөрдөж эхлээд байна.

### **СТОУС 16 - Түрээс**

Компани нь 2019 оны 1-р сарын 1-нээс эхлэх санхүүгийн жилийн санхүүгийн тайлагналдаа СТОУС 16 стандартыг мөрдөж эхэлсэн. 2018 онд танилцуулсан мэдээлэл нь НББОУС-ын 17 стандартын дагуу танилцуулагдаж байсан.

Уг стандарт нь нягтлан бодох бүртгэлийн нэг түрээслэгчийн загварыг танилцуулсан ба үндсэн хөрөнгө нь бага өртөгтэй биш бол 12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг түрээслэгчид тавьдаг.

Компанийн оффисын түрээс, ажилтнуудын байрын түрээс зэрэг нь бүгд 12 сараас доош хугацаатай тул энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компани нь хөрөнгө ашиглах эрх, түрээсийн өр төлбөргүйг хүлээн зөвшөөрсөн.

Компанийн төв оффисын түрээсийг таван жилээр хийсэн нь 2019 оны 9 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон.

### **СТОУТХ 23: Орлогын татварын тодорхойгүй байдал**

2017 оны 6 сарын 7-нд СТОУТХ 23 Орлогын татварын бүртгэлийн тодорхойгүй байдал тайлбарыг НББОУС3-өөс гаргасан. Энэхүү тайлбарт орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд өнөөгийн болон хойшлогдсон татварын өр төлбөр, хөрөнгийг хэрхэн бүртгэх талаар тайлбарласан.

Компани нь одоогоор хойшлогдсон татварын өр төлбөр, хөрөнгө хүлээн зөвшөөрөөгүй тул СТОУТХ 23 нь санхүүгийн тайланд ямарваа нөлөө үзүүлэхгүй болно.

## **Мөрдөгдөж эхлээгүй байгаа нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд**

2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг боловсруулахад ашиглаагүй дараах стандартууд нь ОУСББ-ын тайлант хугацааны дараа жилийн тайлангаас эхлэн мөрдөгдөх болно.

### **НББОУС 1 – Санхүүгийн тайлан бэлтгэх болон НББОУС 8 – Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба алдаа**

2018 оны 10 сарын 31-ээс НББОУС 1 – Санхүүгийн тайлан бэлтгэх болон НББОУС 8 – Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба алдаа стандартуудад НББОУС3-өөс өөрчлөлт оруулсан. Энэ нь СТОУС-ын хүрээнд материаллаг байдлын тодорхойлолтыг тодорхой болгох зорилготой. Энэхүү өөрчлөлт нь 2020 оны 1 сарын 1-ээс эхлэх санхүүгийн жилээс мөрдөгдөж эхэлнэ. Энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт орохгүй гэж үзэж байна.

### **СТОУС 3 – Бизнесийн Нэгдэл**

2018 оны 10 сарын 22-оос эхлэн СТОУС 3 Бизнесийн нэгдэл стандартад өөрчлөлт оруулсан ба бизнесийн тодорхойлолтыг нарийвчлах, шалгалтыг нэвтрүүлэх зорилготой, энэ нь тодорхой тохиолдолд нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагагүй болгоно. Энэхүү өөрчлөлт нь 2020 оны 1

сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлснээр Компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй.

## Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл

### Санхүүгийн хэрэглүүр

Компанийн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн нь дансны үнэтэйгээ ойролцоо гэж үзэв. Бодит үнэ цэн гэдэг нь зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө борлуулсны дүнд хүлээн авах үнэ эсвэл дэс дараатай хэлцэл гүйлгээгээр өр төлбөрийг шилжүүлэхээр харилцан тохиролцож, хэлцлийн өдрөөр үнэлэгдэх үнэ юм. Бодит үнэ цэнийн эрэмбэ нь бодит үнэ цэнийг хэмжих үнэлгээний аргад өгөгдлийг ангилах түвшнүүдийг тогтоодог.

Түвшин1: Идэвхтэй зах зээлд нэг төрлийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн өгөгдөл нь тогтоосон үнэтэй байна.

Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн тогтоосон үнийн 1-р түвшинд багтсан үнээс бусад өгөгдөл шууд (жишээ нь үнэ) эсвэл шууд бус (жишээ нь үнээс гаралтай)

Түвшин 3: Өгөгдөл нь хэмжиж болохуйц бус (зах зээлийн үйл ажиллагаа бага, эсвэл огт дэмждэггүй) байна.

### Бодит үнэ цэн

2018 оны 12 сарын 31-нээс 2019 оны 12 сарын 31 хүртэл хугацаанд Түвшин 1, Түвшин 2, Түвшин 3-ын хооронд ангилагдсан хөрөнгө, өр төлбөрийн хэлцэл гүйлгээ байхгүй байна. Дараах хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн болон эрэмбэд эзлэх түвшнийг харуулав.

	2019.12.31			2018.12.31		
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Бодит үнэ цэнээр үнэлэгдсэн хөрөнгө ба өр төлбөр						
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах Авлага	\$ 5,106,863	\$ -	\$ -	\$ 1,748,249	\$ -	\$ -
Хөрвөх нөхцөлтэй зээл - хөрвөх опцион	-	70,361	-	-	113,412	-
	-	(1,927,151)	-	-	-	-

### Бусад эрсдэлүүд

Компани нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа голчлон хайгуулын үр дүн, металл болон түүхий эдийн үнэтэй холбоотой эрсдэл, тодорхой бус байдалтай тулгардаг. Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйл ажиллагааны хөгжүүлэлт нь олон эрсдэл дагуулдаг бөгөөд дийлэнх нь Компанийн хяналтаас давсан байдаг. Компани нь дэд бүтэц сул хөгжсөн алслагдмал байршилд үйл ажиллагаа явуулдаг гадна хайгуул, ашиглалтын хэвийн болон ердийн эрсдэлүүдтэй тулгарч байдаг. Эдгээр эрсдэлүүдийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR [www.sedar.com](http://www.sedar.com)-д байрлах Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс танилцах боломжтой.

### Зээлийн эрсдэл

Компани нь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын томоохон санхүүгийн институтэд хадгалуулж, бэлэн мөнгөний эрсдэлийг бууруулах боломжтой гэж Компанийн удирдлага үздэг. 2019 оны 12 сарын 31-ний байдлаар нийт мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 1% буюу \$60,511 долларыг Канадаас өөр улсад хадгалуулж байна (2018 - \$66,342 буюу 4%).

### Хөрвөх чадварын эрсдэл

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

**Компани нь 2020 оныг дуустал нийт төлөвлөсөн зардлыг хангахад шаардлагатай эргэлтийн хөрөнгө байхгүй тул үйл ажиллагааг тасалдуулахгүйн тулд нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлэх шаардлагатай.**

### Хүүгийн эрсдэл

2019 оны 12 сарын 31-ний байдлаар Компанийн хөрвөх боломжтой зээл нь 10%-ийн тогтмол хүүтэй тул хүүгийн эрсдэлийн хэлбэлзэлд хамаарахгүй.

## Гадаад валютын эрсдэл

Эрдэнэ Ресурс нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг тул гадаад валютын хөрвүүлгийн ханшийн эрсдэлтэй. Уг эрсдэлийг бууруулах зорилгоор Компани нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын нэр хүндтэй санхүүгийн байгууллагад байршуулдаг. Компани нь гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалан хязгаар тогтоох санхүүгийн хэлцлүүдийг ашигладаггүй бөгөөд төсвийн хэмжээнд нийцүүлэн ханш боломжийн байх үед гадаад валютыг урьдчилан худалдаж авдаг.

Компани нь хөрвөх нөхцөлтэй зээлтэй холбоотойгоор ам.долларын гадаад валютын эрсдэл хүлээх магадлалтай. Хугацаа дуусахад 5 сая ам.долларын үндсэн зээл ба капиталжсан хүүгийн төлбөр бүрэн төлөгдөнө. Иймд Компани нь кан/ам долларын ханшийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэлд орох магадлалтай.

Компанийн ам.долларын ханшийн эрсдэлд өртөх магадлалтай хөрөнгө 2019 оны 12 сарын 31-ний байдлаар (\$1,561,424) (2018.12.31 - \$71,913) байна. Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$156,100 (2018.12.31 - \$7,200) долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай.

Компанийн монгол төгрөгийн ханшийн эрсдэлд өртөх магадлалтай хөрөнгө 2019 оны 12 сарын 31-ний байдлаар (\$55,661) (2018.12.31 - (\$11,509)) байна. Төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$5,600 (2018.12.31 - \$1,200) долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай.

## Үнийн эрсдэл

Компани нь тодорхой ашиггүй тул түүхий эдтэй холбоотойгоос бусад санхүүгийн хэрэгсэл, хайгуул, олборлолтын салбар дахь компаниудад нөлөөлдөг үнийн хэлбэлзэл, үнийн шууд эрсдэлд өртөхгүй.

## Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт

Эрдэнэ Ресурс нь Канад Улсын үнэт цаасны зохицуулалтын 52-109 стандартаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх захирал (ГЗ), Санхүү хариуцсан захирал (СХЗ) нар Эрдэнэ Ресурсийн 2019 оны 12 сарын 31-ний байдлаар толилуулгын хяналт, процедурын зохион байгуулалт, үр нөлөөг үнэлж үзээд эдгээр процедур нь Эрдэнэ Ресурс, түүний охин компаниудтай холбоотой материаллаг мэдээллийг бусдадаа үнэн зөв, бүрэн бүтэн толилуулах, жилийн тайлагналыг үндэслэлтэй гаргах боломжийг бүрдүүлсэн, үр нөлөөтэй байна хэмээн дүгнэсэн.

ГЗ, СХЗ-ыг багтаасан Эрдэнэ Ресурсийн удирдах баг (хамтад нь “Удирдах баг” гэх) нь санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Санхүүгийн тайлагналд тавих Эрдэнэ Ресурсийн дотоод хяналт (аудит) нь санхүүгийн тайлагналын найдвартай байдлыг хангаж, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд анхаарна.

Удирдлага нь 2019 оны 12 сарын 31-ний байдлаар Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтын хэрэгжилт, үр нөлөөг үнэлсэн. Ийнхүү үнэлэхдээ Удирдлага нь Ивээн тэтгэгч байгууллагуудын хороо (“Committee of Sponsoring Organizations of the Treadway Commission”)–ны “Дотоод хяналт - нэгдсэн зохицуулалтын орчин (2013)” гэх тайланд тогтоосон шалгууруудыг ашигласан. Үнэлгээгээр гол эрсдэлтэй салбаруудын хяналтыг шалгаж, эдгээр хяналтуудын хэрэгжилтийг үнэлж, үр нөлөөг нь тодорхойлох зорилгоор тэдгээр хяналтуудыг туршиж, үр дүнг нь хянаж, улмаар нэгдсэн дүгнэлт гаргасан.

Удирдлагын үнэлгээнд үндэслэн ГЗ болон СХЗ нар 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналт нь санхүүгийн тайлагналын үнэн зөв, найдвартай байдлыг хангах, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд үр нөлөөтэй байна гэж дүгнэсэн.

Хэдийгээр дээрх систем нь үр дүнтэй хэмээн тодорхойлогддог боловч энэ нь зөвхөн санхүүгийн тайлангийн боловсруулалт болон бэлтгэлийн хувьд хамаарна. Мөн тооцооллуудын төсөөлөл нь ямар нэгэн нөхцөл байдал, зөвшөөрөл, бодлого дүрэм журмуудын өөрчлөлтөөс шалтгаалан ирээдүйд удирдах боломжгүй эрсдэл дагуулах боломжтой.

## Мэргэшсэн этгээд

Петер Далтон, Р.Гео, (Нова Скотиа) нь NI 43-101 стандартын шаардлага хангасан мэргэшсэн этгээд бөгөөд Компанийн хайгуулын бүх геологийн хөтөлбөрийг удирдан чиглүүлнэ. Дээжийг Монгол Улсын Улаанбаатар хот эсвэл БНХАУ-ын Тяньжинд байрлах Эс Жи Эс лаборатори (“SGS Laboratories”), Улаанбаатар хот дахь Геологийн төв лаборатори, Канадын Бритиш Колумбийн муж дахь Блю Коуст Рисерч Лтд (“Blue Coast Research Ltd”) эсвэл Канадын Ванкувер хотод төвтэй ALS Chemex

лабораторид тус тус шинжлүүлдэг. Эс Жи Эс лаборатори, Геологийн төв лаборатори, ALS Chemex лабораторийн дотоод хяналтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн эрдэсжилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэдэг.

Энэхүү УХДШ-д толилуулсан Компанийн эзэмшиж буй ашигт малтмалын төслүүдийн шинжлэх ухааны болон техникийн мэдээллийг Компанийн хараат мэргэшсэн геосудлаач Петер Далтон хянан баталсан болно.

Энэхүү УХДШ-д багтсан Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын Анхан Шатны Эдийн Засгийн Тооцоололтой (“АШЭЗТ”) холбоотой санхүүгийн загварчлалыг Tetra Tech-ийн ажилтан Марк Хоран (“Mark Horan”) гүйцэтгэсэн. Мөн Tetra Tech-ийн ажилтан Хассан Гаффари (“Hassan Ghaffari”) P.Eng нь УХДШ-д багтсан Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын АШЭЗТ-ын мэдээлэлд багтсан боловсруулалтын загвар, зардлын тооцооллыг хийж, баталгаажуулсан. УХДШ дэх Баян Хөндийн нөөцийн тооцооллыг Tetra Tech-ийн ажилтан Кам Нортон (“Cam Norton”), P. Geo, боловсруулж, баталгаажуулсан. Баян Хөндийн нөөцийн тооцооллыг Tetra Tech-ийн ажилтан Маурий Файфер (Maurie Phifer) P.Eng, боловсруулж баталгаажуулсан. Ноён Хоран, Гаффари, Нортон, хатагтай Файфер нар нь энэ төрлийн орд болон эрдэсжилтийн төрлийн талаар хангалттай мэдлэгтэй, NI 43-101-т заасан мэргэшсэн этгээдүүд юм. Ноён Хоран, Гаффари, Нортон, хатагтай Файфер нар нь Эрдэнэ Ресурстай холбоотой ашиг сонирхлын зөрчил байхгүй болно.

## **Бусад мэдээлэл**

Компанийн талаарх нэмэлт мэдээллийг SEDAR [www.sedar.com](http://www.sedar.com) хаяг болон [www.erdene.com](http://www.erdene.com) хаяг дахь Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс үзэх боломжтой.

*Орчуулга: Энэхүү тайлан нь Англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.*